



ХӨДӨЛМӨРИЙН ЯАМ



МОНГОЛ УЛСЫН ТЕХНИК, МЭРГЭЖЛИЙН
БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫН САЛБАРЫН
ДЭМЖИХ ТӨСӨЛ-1



МЭРГЭЖЛИЙН БОЛОН ТЕХНИКИЙН БОЛОВСРОЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

2016–2021 ОН



ГАРЧИГ

БҮЛЭГ 1

МЭРГЭЖЛИЙН БОЛОН ТЕХНИКИЙН БОЛОВСРОЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР /2016-2021/-ИЙГ БОЛОВСРУУЛСАН СУУРЬ СУДАЛГАА

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

6

1.1 Оршил

6

1.2 Монгол Улсын хөгжилд техник, мэргэжлийн боловсрол, сургалтын оруулж буй хувь нэмэр, ач холбогдол

7

1.3 Хөгжлийн бодлогыг тодорхойлох зургаан суурь хүчин зүйл, ололт амжилт

12

1. Мэргэжлийн боловсрол, сургалтын салбарт хууль, эрх зүйн таатай орчин бүрдэж байна.

2. Мэргэжлийн боловсрол, сургалтыг чадамжид суурилсан сургалтад шилжүүлэн хөгжүүлж байна.

3. Нийгмийн түншлэл, хамтын ажиллагаа сайжирч байна.

4. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын тогтолцооны шинэчлэл

5. Төгсөгчдийн ур чадвар сайжирч, хөдөлмөр эрхлэлт нэмэгдэж байна.

6. Мэргэжлийн боловсрол, сургалтын орчин сайжирч байна.

1.4 Салбарын тулгамдсан асуудлууд, тэдгээрийн шалтгаан

17

1. Салбарын түвшний судалгаа хангалтгүй, хэрэглэгчдэд хүртээмжгүй байна.

2. Нийгмийн түншлэлийг бэхжүүлэх, үр дүнтэй хамтын ажиллагааны хөшүүргийг бий болгох шаардлагатай байна.

3. Мэргэжлийн түвшний үндэсний тогтолцоо бүрдээгүй байна.

4. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын тогтолцооны шинэчлэл

5. Чадамжид суурилсан сургалт, үнэлгээний тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлэх шаардлагатай байна.

6. Сургалтын материаллаг орчин ба менежментийг сайжруулах хэрэгцээ байна.

7. Хүний нөөцийг тасралтгүй хөгжүүлэх тогтолцоо бий болгох хэрэгцээтэй байна.

8. МБС-ын санхүүжилтийн тогтолцоо сул байна.

Мэргэжлийн болон техникийн боловсролыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд хүрэх гол үр дүн

26

ХОЁР. МБС-ЫН САЛБАРЫН ДУНД ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГО ЗОРИЛТ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

28

2.1 Зорилго

2.2 Зорилтууд

2.3 Баримтлах зарчим

2.4 Зорилтыг хангах үйл ажиллагааны чиглэл



ГУРАВ. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, САНХҮҮЖИЛТ	34
3.1 Хугацаа, үе шат	34
3.2 Удирдлага, зохион байгуулалт	35
3.4 Санхүүжилтийн эх үүсвэр	36
ДӨРӨВ. БОДЛОГЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	37
ТАВ. ХЭРЭГЖИЛТИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	38
НОМ ЗҮЙ	39
ЗУРАГ	
Зураг 1. Монголын МБС-ын хөгжлийн түүхэн замналын тойм	
Зураг 2. МБС-ын байгууллагууд, элсэгчдийн тоо /сүүлийн 5 жилээр/	
Зураг 3. Төсөл хөтөлбөрүүд, санхүүжилт (2008-2015 он), сая ам.доллараар	
Зураг 4. Мэргэжлийн боловсрол, сургалтын тогтолцоо	
Зураг 5. Монгол улсад хөдөлмөр эрхэлсэн гадаадын иргэд (2011-2014 он)	
Зураг 6. Хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл авсан гадаад иргэд, эдийн засгийн салбараар	
Зураг 7. Суралцагчдын насны бүтэц, 2015-2016 оны хичээлийн жил	
Зураг 8. МБС-ын байгууллагуудын бэлтгэж буй мэргэжлийн чиглэл, бүсээр	
Зураг 9. МБСБ-ын хүний нөөц, үндсэн багш нарын бүтэц	
Зураг 10. Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалт	
Зураг 11. Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт	
ХҮСНЭГТ	
Хүснэгт 1. Салбарын багшийг хөгжүүлэх тогтолцооны өнөөгийн байдал	
Хүснэгт 2. Үндсэн зорилтууд, тэдгээрийн үр ашиг, анхаарах асуудал	
ШИГТГЭЭ	
Шигтгээ 1. Мэргэжлийн болон техникийн боловсрол сургалт гэж юу вэ?	
Шигтгээ 2. Сургалтын байгууллагыг төрөлжүүлэх нь ямар ач холбогдолтой вэ?	
ХАВСРАЛТ	41
Хавсралт 1. ЧСС-ын хөтөлбөр болон ажил мэргэжлийн лавлахын жагсаалт	
БҮЛЭГ 2	43
АЛБАН ЁСООР БАТАЛГААЖСАН МЭРГЭЖЛИЙН БОЛОН ТЕХНИКИЙН БОЛОВСРОЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР/2016-2021/	43
Үндэсний хөтөлбөр батлах тухай	44
Засгийн газрын 2016 оны 6 дугаар сарын 6-ны өдрийн 304 дугаар тогтоол	



ӨМНӨХ ҮГ



Дэлхий нийтээр даяарчлагдан шинжлэх ухаан, мэдээллийн технологи хурдацтай хөгжиж, улс төр, эдийн засгийн интеграцлал өргөжиж байгаа өнөө үед мэргэжлийн боловсрол, сургалтын салбарыг олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлж, хөдөлмөрийн зах зээлд эрэлттэй ур чадвар бүхий мэргэжилтнийг бэлтгэх нь улс орны анхаарлын төвд байх асуудал билээ.

Засгийн газрын бодлого, үйл ажиллагааны хөтөлбөрт тогтвортой, биеэ даасан, өрсөлдөөнт эдийн засгийг хөгжүүлэхэд чиглэсэн макро-эдийн засгийн тэргүүлэх зорилтуудыг дэвшүүлсний нэг нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажилтай орлоготой монгол хүний асуудал юм. Ийнхүү хөдөлмөр эрхлэлтэд анхаарал хандуулж буй зорилго нь хөдөлмөрийн зах зээлд ур чадвартай ажилчдын эрэлтийг зохистой хангах явдал юм. Бид ирэх 30 хүрэхгүй он жилүүдэд эдийн засгийн өсөлтөө эрчимжүүлж, их бүтээн байгуулалтыг залуу, эрч хүчтэй, хөдөлмөрийн насны хүн амдаа тулгуурлан бий болгох шаардлага тулгарч байгаа бөгөөд аль ч салбарт шаардлагатай ур чадвартай мэргэжилтэй ажилчдыг хөдөлмөрийн зах зээлд чанартай бэлтгэн нийлүүлж ажиллах ёстой болоод байна.

Энэ хүрээнд мэргэжлийн боловсрол, сургалтын салбарын шинэчлэл нь төр, хувийн хэвшлийн бодит түншлэл, шинэ технологи, шилдэг сургалтын арга зүйд тулгуурлан хөгжих ёстой. Сүүлийн жилүүдэд мэргэжлийн боловсрол, сургалтыг хөгжүүлж, олон нийтийн дундах хандлага, ойлголтыг өөрчлөхөд төр, хувийн хэвшил, донор, төсөл хөтөлбөрийн байгууллагууд хамтран ажиллаж багагүй амжилтад хүрлээ. Салбарт гарч буй өөрчлөлт, шинэчлэлийг тогтвортой хангах бодлогын баримт бичгийг боловсруулан ойрын таван жилд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг бодит судалгаа, тооцоолол, нотолгоонд үндэслэн тодорхойллоо. Төлөвлөсөн арга хэмжээ бүр түншлэл, хамтын ажиллагаанд тулгуурлан хэрэгжиж, хэмжигдэхүйц шалгуур үзүүлэлтийг ханган дараа дараагийн хөгжлийн бодлогыг тодорхойлох суурь хүчин зүйл болох учиртай. Мэргэжлийн бахархал, үнэ цэнийг бий болгоход салбарын энэхүү бодлого төлөвлөлт үр дүнгээ өгнө гэдэгт итгэлтэй байна.

Мэргэжлийн боловсрол, сургалтын салбар хөгжихийн хэрээр өндөр ур чадвартай мэргэжилтэй ажилтнууд төрөн гарч, үйлдвэрлэгч, бүтээгч улс болж, хөгжин цэцэглэх болтугай.

Таныг хүнэтгэсэн

УИХ-ын гишүүн, Засгийн газрын гишүүн, Хөдөлмөрийн сайд

Гарьдхүүгийн БАЯРСАЙХАН

МЭРГЭЖЛИЙН БОЛОН
ТЕХНИКИЙН БОЛОВСРОЛЫГ
ХӨГЖҮҮЛЭХ ҮНДЭСНИЙ
ХӨТӨЛБӨР /2016-2021/-ИЙГ
БОЛОВСРУУЛСАН СУУРЬ
СУДАЛГАА





НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 ОРШИЛ

“Мэргэжлийн болон техникийн боловсролыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг боловсруулахдаа Мэргэжлийн боловсрол сургалтын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Боловсролын тухай хууль, Төсвийн тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулсан.

Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого (2014-2024 он), Боловсрол Үндэсний хөтөлбөр (2010-2021 он) зэрэг бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан зорилт, үйл ажиллагааг уялдаа, холбоотой хэрэгжүүлэхэд чиглэсэн.

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 326 дугаар тогтоолд “мэргэжлийн боловсрол, сургалтыг хөгжүүлэх стратегийг тодорхойлж, чадамжид суурилсан тогтолцоог бүрдүүлэхэд чиглэсэн Мэргэжлийн боловсрол, сургалтыг хөгжүүлэх мастер төлөвлөгөө”-г боловсруулж батлах, Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 196.1-д “Мэргэжлийн боловсрол, сургалтыг хөгжүүлэх мастер төлөвлөгөө”-г батлан хэрэгжүүлэхээр тус тус заасан нь Мэргэжлийн боловсрол, сургалтыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийн үндэслэл болж байна.

Мэргэжлийн боловсрол, сургалтын салбарын шинэчлэл нь хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцүүлэх, төр, хувийн хэвшлийн түншлэлийн бодит механизм бүрдүүлж төлөвшүүлэх, үйлдвэрлэлийн хөгжлийн хэрэгцээтэй холбож төрөлжүүлэх, сургалтын стандарт, хөтөлбөрийг шинэчлэх, багш нарыг заах арга зүй болон мэргэшсэн инженер техникийн ажилтны түвшинд хүргэж чадваржуулах, үйлдвэрлэл-дадлагын сургалтын бааз, лабораторийг орчин үеийн шаардлагад нийцүүлэх, сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүнээр хангах, иргэдийн хэрэгцээнд суурилсан үйлчилгээг нэвтрүүлэх, эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх асуудлыг хамарч байна.

Мэргэжлийн боловсрол, сургалтыг хөгжүүлэхэд төр, хувийн хэвшил болон олон улсын донор байгууллагуудын хамтын ажиллагаа өргөжиж байгаагийн хэрээр бүс нутгийн хөгжил, байгаль орчны тогтвортой байдлыг хангахад чиглэсэн салбар дундын зохицуулалт бүхий тогтолцооны шинэчлэл хийх шаардлага урган гарч байна.

Сүүлийн жилүүдэд хийгдэж байгаа салбарын шинэчлэлээс олж авсан ололт амжилт болон тулгамдаж буй асуудал, тэдгээрийн шалтгаан, холбогдох бодлогын баримт бичигт тусгагдсан зорилтыг цогцоор нь авч үзэн салбарын хөгжлийн зорилго, зорилтууд болон 2016-2021 онд хэрэгжүүлэх дунд хугацааны хөгжлийн баримт бичгийг тодорхойлсон болно.

Тус баримт бичгийг боловсруулахдаа ЮНЕВОК¹-оос техник, мэргэжлийн боловсрол сургалтын салбарт санал болгож буй стратегийн чиглэл, Австрали,

Холбооны Бүгд Найрамдах Герман Улс, Бүгд Найрамдах Сингапур Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс, Иреланд Улс зэрэг олон орнуудын МБС-ын

¹ ЮНЕВОК (UNESCO-UNEVOC) нь ЮНЕСКО-гийн төрөлжсөн 8 байгууллагуудын нэг бөгөөд гишүүн орнуудын ТМБС-ын салбарыг хөгжүүлэх, бэхжүүлэхэд дэмжлэг тусалцаа үзүүлэх чиг үүрэгтэйгээр 1999 оны ЮНЕСКО-гийн 30 дугаар нэгдсэн чуулганы шийдвэрээр байгуулагдсан олон улсын төв байгууллага юм.



стратеги төлөвлөгөө, туршлагауд бүхий томоохон бодлогын баримт бичгүүд, Монгол Улсын МБС-ын талаарх олон улсын зөвлөхүүдийн боловсруулсан зөвлөмж, стратегийн баримт бичгүүд, мөн монголын судлаачдын эрдэм шинжилгээний нийтлэл, салбарын статистик тоо баримт зэрэг олон эх үүсвэр бүхий баримт, материалуудыг судалж, ашигласан болно.

1.2 МОНГОЛ УЛСЫН ХӨГЖИЛД МЭРГЭЖЛИЙН БОЛОН ТЕХНИКИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫН ОРУУЛЖ БУЙ ХУВЬ НЭМЭР, АЧ ХОЛБОГДОЛ

Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалт (МБС) нь үйлдвэрлэл, бүтээн байгуулалтын салбарын ажиллах хүчнийг бэлтгэж, нийгэм, эдийн засгийн хөгжилд үнэтэй хувь нэмрээ оруулж байна. Өөрөөр хэлбэл МБС-ын салбар нь барилга, уул уурхай, хүнс хөдөө аж ахуй, аж үйлдвэр, зам тээвэр, үйлчилгээ зэрэг тэргүүлэх салбарт мэргэжилтэй ажилтны эрэлтийг хангаж, хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжин, ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, эдийн засаг, нийгмийн тогтвортой хөгжлийг хангахад хөгжлийн түлхүүр болох салбар юм.

Шигтгээ 1.


Мэргэжлийн болон техникийн боловсрол сургалт гэж юу вэ?

Мэргэжлийн болон техникийн боловсрол сургалт (МБС) нь бүх төрлийн үйлдвэрлэл, үйлчилгээний салбарт ажиллах болон амьдрах арга ухааныг эзэмшүүлэхэд чиглэсэн боловсрол, сургалт, болон ур чадварын нэгдмэл ойлголт юм. МБС-ыг ерөнхий боловсролын дунд, ахлах болон дээд боловсролын түвшинд эзэмшүүлж болох ба ажлын байран дээрх сургалт болон мэргэжил дээшлүүлэх бусад сургалтыг явуулах замаар тасралтгүй мэргэшүүлдэг насан туршийн боловсролын тогтолцооны нэг хэсэг юм. МБС нь тухайн орны үндэсний болон орон нутгийн онцлогт нийцүүлэн иргэдийн ур чадварыг хөгжүүлэхэд чиглэсэн олон талт үйл ажиллагааг агуулдаг. Мөн суралцах чадвар, эх хэлний боловсрол, тооцоолон бодох чадвар, нийгэмшихүйн болон иргэншихүйн ур чадварууд нь МБС-ын үндсэн бүрдэл хэсгүүдэд багтана (UNESCO-UNEVOC¹).

Монгол Улсын ТМБС-ын үндэс суурь тавигдсан он жилийг судлавал 90 гаруй жилийн түүхэн хөгжлийг туулсан ууган салбаруудын нэг бөгөөд аж үйлдвэрийн салбарын үүсэл хөгжилтэй холбон авч үзсэн судалгаа олонтаа байна. 1921 оноос эхлэн Телефон цахилгаан мэдээний албан хаагч, ноос угаах цехийн ажилтан бэлтгэх сургууль, Мал адгуусыг эмчлэн сувилах сургууль зэрэг байгуулагдснаар салбарын үүсэл хөгжлийн үндсэн суурь тавигдсан гэж үздэг. Улмаар 1960-1990 онд нийт МБС-ын байгууллагын тоо 46 болтлоо өсч байсан бол 1990 оноос хойш нийгэм, эдийн засгийн өөрчлөлтийн улмаас салбар уналтад орж, 31 болтлоо буурсан байна. Сүүлийн жилүүдэд салбарын хөгжилд онцгой анхаарал хандуулах болсноор 2015 оны байдлаар нийт 81 МБС-ын байгууллага (төрийн өмчийн 49, хувийн 32), 4520 багш, ажилчидтай, 193 мэргэжлээр жилд дунджаар 20 орчим мянган мэргэжилтэй ажилтныг бэлтгэдэг салбар болж өргөжин хөгжиж байна.

Судлаачдын дүгнэлтээр салбарын үүсэл, хөгжлийг үндсэн дөрвөн хэсэгт тодорхойлсон байна. Зураг 1-т үүсэл, хөгжлийн тоймыг харууллаа.

Зураг 1. Монгол Улсын ТМБС-ын үүсэл, хөгжлийн түүхэн замналын тойм⁴




⁴Мэргэжлийн боловсрол, сургалтын тогтолцооны үүсэл, хөгжил, шинэчлэл, Эрдэм шинжилгээний бичиг, 2014 он



Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулинд “Мэргэжлийн боловсрол, сургалтын зорилго нь иргэний авьяас, сонирхол, хөдөлмөр эрхлэх хэрэгцээнд тулгуурлан боловсролын үндсэн зарчим, олон улсын нийтлэг жишиг, хандлагад нийцүүлэн мэргэжлийн ур чадвар, боловсрол эзэмшүүлэх, мэргэшлийг дээшлүүлэх, хөдөлмөрийн болон харилцааны соёл төлөвшүүлэхэд оршино” гэж заасан байна (хуулийн 5.1 дэх хэсэгт).

Монгол Улсын МБС-ын байгууллагуудын болон элсэгчдийн тооны өсөлтийг Зураг 2-т харууллаа.

Зураг 2. МБС-ын байгууллагууд, элсэгчдийн тоо /сүүлийн 5 жилээр/



Эх сурвалж: Хөдөлмөрийн яамны статистик тоо мэдээлэл

Боловсролын бодлогын үндсэн зарчим, олон улсын нийтлэг жишиг, хандлагыг эрхэм болгодог МБС нь иргэний авьяас, сонирхол, хөдөлмөр эрхлэх хэрэгцээнд нь нийцүүлэн мэргэжлийн ур чадвар эзэмшүүлэх, мэргэжил дээшлүүлэх, хөдөлмөрийн болон харилцааны соёл төлөвшүүлэх зорилготой². Техникийн ба мэргэжлийн боловсрол олгох сургалт нь чадамжийн гэрчилгээ олгох (түр сургалтын), мэргэжлийн боловсрол эзэмшүүлэх (1 ба 2.5 жил), техникийн боловсрол эзэмшүүлэх (1.5 ба 3 жил) гэсэн сургалтын үндсэн хэлбэрүүдтэйгээр зохион байгуулагддаг ба 2015-2016 оны байдлаар нийт суралцагчдын дийлэнх нь буюу 82.9% нь мэргэжлийн боловсрол, 15.6% нь техникийн боловсролын сургалтад хамрагдаж, үлдсэн 1.5% нь чадамжийн гэрчилгээ олгох түр сургалтад суралцаж байна.


² Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 5.1-р заалт



МБС-ын салбарын өнөөгийн хүрсэн түвшин нь төрөөс авч хэрэгжүүлсэн дараах арга хэмжээнүүдтэй салшгүй холбоотой. Үүнд:

- **Хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох:** Анх 2002 онд батлагдсан Мэргэжлийн боловсрол сургалтын тухай хуулинд 2009 онд шинэчилсэн найруулга, 2012, 2016 онд нэмэлт өөрчлөлтүүдийг тус тус хийж, агуулгын болон томоохон шинэчлэлүүдийг тусгаж ирсэн.
- **Институт, дэд бүтцийг бий болгох:** Эдийн засгийн бүсчилсэн хөгжлийн бодлогод нийцүүлэн 6 Бүсийн арга зүйн төвүүдийг байгуулж, чиг үүргийг МБС-ын тухай хуулинд зааж өгсөн. Мөн ММСС-ын дэмжлэгтэйгээр МАЗҮТ, “Оюу-толгой” ХХК-ний дэмжлэгтэйгээр Багшийн хөгжлийн төвийг түр хугацаагаар байгуулан ажилласан ба 2016 оны МБС-ын тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөөр дээрх байгууллагуудын үндсэн чиг үүргүүдийг хэрэгжүүлэх Үнэлгээ, мэдээллийн төвийг байгуулж, эрх зүйн статусыг хуульчлан батлаад байна.
- **Бодлогын бичиг баримт, тусгай зорилтот хөтөлбөрүүдийг боловсруулж, хэрэгжүүлэх:** МБС-ын талаар баримтлах бодлогын хүрээнд Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого, “Ажилтай, орлоготой Монгол хүн” үндэсний хөтөлбөр, “МБС-ын багшийн хөгжил” хөтөлбөр зэргийг дурдаж болно.
- **Санхүүжилтийн олон эх үүсвэрийг бий болгох:** Салбарт улсын төсвийн хөрөнгө оруулалтаас гадна олон эх үүсвэртэй төсөл хөтөлбөрүүд хэрэгжиж, хувийн хэвшлийн оролцоог дэмжин ажилласан нь салбарын санхүүжилт, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлсэн. МБС-ын салбарт 2008 оноос донор байгууллагуудын төсөл хөтөлбөрүүд хэрэгжиж, биет болон биет бус хөрөнгө оруулалт хийгдсэн (Зураг 3).

Зураг 3. Төсөл хөтөлбөрүүд, санхүүжилт (2008-2015 он), сая ам.доллараар



Төсөл-1: ММСС-ын МБС-ын төсөл

Төсөл-2: ЧСС-ын хөтөлбөр боловсруулах аргачлал, насанд хүрэгчдийн заах арга зүйн төсөл

Төсөл-3: Баруун бүсийн МБС

Төсөл-4: Ашигт малтмалын салбар дахь түншлэлд суурилсан МБС

Төсөл-5: КОЙКА-ын Монгол-Солонгосын Политехник коллежийн чадавхийг бэхжүүлэх төсөл

Төсөл-6: Энэтхэгийн ЗГ-ын Үйлдвэрлэл-Урлалын Политехник коллежийг хөгжүүлэх төсөл

Төсөл-7: МБС-ын салбарын чанарын баталгаажуулалтыг сайжруулах

Төсөл-8: НҮБ-ын Хүн амын сан

Төсөл-9: БНЧУ-ын Хөгжлийн Агентлаг. Каритас сан. Пипл Ин Нийд ОУТББ

Төсөл-10: Швейцарийн хөгжлийн агентлаг/SDC/

Төсөл-11: Сингапурын Темасексан

Төсөл-12: 2Германы олон улсын хамтын ажиллагааны төсөл /GIZ/

Төсөл-13: Оюутолгой ХХК

Төсөл-14: ЗНҮБ-ын Хүн амын сангийн төсөл/UNFPA/

Төсөл-15: Европын холбоо/EU/-ны МБСДТ-1 төсөл

Төсөл-16: Европын холбоо/EU/-ны МБССДТ-2 төсөл

Төсөл-17: Азийн хөгжлийн банк/ADB/

Эх сурвалж: ХЯ болон МБС түншлэл ТББ-ын судалгааны тайлан, мэдээлэл



1.3 ХӨГЖЛИЙН БОДЛОГЫГ ТОДОРХОЙЛОХ ЗУРГААН СУУРЬ ХҮЧИН ЗҮЙЛ, ОЛОЛТ АМЖИЛТ

Мэргэжлийн боловсрол, сургалтын салбарыг тогтвортой хөгжүүлэх гол зарчим нь сүүлийн жилүүдэд хийгдэж байгаа шинэчлэлийн давалгаанд салбарт бий болсон ололт, амжилтыг үндэслэл болгож, тулгамдаад буй асуудлыг бүрэн шийдвэрлэх шинэ санаачлага бүхий бодлогын арга хэмжээг оновчтой тодорхойлох асуудал юм. Иймд техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалтын салбарт бий болоод байгаа хэд хэдэн ололт, амжилтыг дараах байдлаар тодорхойлж байна.

1. МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫН САЛБАРТ ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ТААТАЙ ОРЧИН БҮРДЭЖ БАЙНА.

Техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалтын харилцааг 2002 он хүртэл “Боловсролын тухай” болон “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай” хуулийн хүрээнд зохицуулж ирсэн. УИХ 2002 онд “Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай” анхны бие даасан хуулийг батлан гаргаснаар техник, мэргэжлийн боловсрол, сургалтыг хөдөлмөрийн зах зээлд нийцүүлэх асуудалд анхаарал хандуулах болсон.

МБС-ын тухай хуульд 2009 онд нэмэлт өөрчлөлт оруулснаар олон улсын жишигт нийцсэн мэргэжлийн боловсрол, сургалтын шинэ тогтолцоо, холбогдох үйл ажиллагааны шинэчлэлийн эрх зүйн орчин бүрдсэн. Үүнд МБС-ын дээд удирдлагыг төр хувийн хэвшлийн тэнцүү оролцоотой Үндэсний зөвлөл хэрэгжүүлэх, сургалтын агуулга, стандартыг шинээр тодорхойлох, багш, суралцагч, сургуулийн эрх хэмжээ, чиг үүргийг боловсронгуй болгох, түншлэлийг хөгжүүлэх, МБС-ыг Дэмжих санг бий болгож, ажиллуулах тодорхой асуудлуудыг тусгасан нь тухайн үед өөрчлөлт шинэчлэлтийг дэмжсэн томоохон шийдвэртэй алхам болсон. Мөн ХЗЗ-ийн эрэлт, ажил олгогчийн хэрэгцээ шаардлагыг хангахуйц ур чадвартай мэргэжилтэй ажилтныг бэлтгэх, төгсөгчдийг ажлын байртай болгох зорилгоор 2012 онд Хөдөлмөрийн яамны эрхлэх асуудалд МБС-ыг хамааруулсан нь бодлогын томоохон шинэчлэл болсон.

Салбарыг хөгжүүлэх шинэчлэлийн үйл ажиллагааны үр дүнд шийдвэрлэх шаардлагатай асуудлууд урган гарснаар 2016 оны 02 дугаар сарын 4-ний өдрийн УИХ-аар МБС-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан. Хуулийн нэмэлт өөрчлөлтөөр МБСҮЗ–ийн эрх, үүргийг тодорхой болгож, салбарын тогтолцоонд Үнэлгээ, мэдээллийнтөвийг шинээр оруулан мэргэжлийн ур чадварыг үнэлэх, шалгах, баталгаажуулах хөндлөнгийн шалгалт зохион байгуулах, статистикийн болон бусад мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлж ажиллах зэрэг чухал заалтуудыг оруулсан. Мөн аж ахуйн нэгж, байгууллагад үйлдвэрлэлийн дадлагажуулагч багш бэлтгэж ажиллуулах, нийгмийн түншлэлийг хөгжүүлэх, эрэлтийн судалгааг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гаргах, МБС-ын байгууллага өөрийн үйл ажиллагаанаас орлого олох, зарцуулах асуудлыг дэмжсэн чухал заалтуудыг хуулинд тусгаад байна.



2. МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫГ ЧАДАМЖИД СУУРИЛСАН СУРГАЛТАД ШИЛЖҮҮЛЭН ХӨГЖҮҮЛЖ БАЙНА.

МБС-ын салбарыг системээр нь өөрчлөн хөгжүүлэх, олон улсын түвшинд хүргэхэд ЧСС-ын тогтолцоог бүрдүүлэх асуудал тэргүүнд тавигдаж, олон улсын туршлагыг нэвтрүүлэх асуудлын хүрээнд томоохон донор байгууллагууд хамтран ажиллаж байна. Шинэчлэлийг эхлүүлэхэд АНУ-ын Мянганы сорилтын сангийн компакт гэрээний дагуу 2008-2012 онд төсөл хэрэгжиж үнэтэй хувь нэмэр оруулсан нь дараа дараагийн донор байгууллагуудын хамтын ажиллагаа өргөжих үндэс суурь болсон.

Чадамжид суурилсан сургалтын гол зарчим нь мэргэжлийн ур чадварыг академик онолоос илүүтэй дадлага ажил, практик сургалтад суурилан орчин үеийн технологид нийцсэн дадлагын орчинд тоног төхөөрөмж багаж, хэрэгсэлд гараар хүрч ажиллан бодитоор мэдрэн сурах замаар олгоход чиглэдэг тул онолын мэдлэгийг 20 хувь, дадлага ажлаас олж авах мэдлэгийг 80 хувьд хүргэхэд анхаарч байна. Үүний дагуу МБСБ-уудын дадлагын орчинг сайжруулах, ажил олгогчидтой хамтарсан ажлын байран дахь сургалтын үйл ажиллагааг өргөжүүлэхээр ажиллаж байна.

ЧСС-ын тогтолцоонд шилжих ажил 2008 оноос эрчимтэй хэрэгжиж эхэлсэн. Үүнд салбарын хүний нөөцийг хөгжүүлэх, удирдах ажилтан, багш мэргэжилтнүүдийг чадавхижуулах, ЧСС-ын шинэ стандарт, хөтөлбөр боловсруулах, үнэлгээний шинэ тогтолцоонд шилжүүлэх, Мэргэшлийн түвшний үндэсний тогтолцоо (МТҮТ)-г бүрдүүлэх, шаардлага хангасан ном, сурах бичгийг боловсруулж, түгээх, салбарт жишиг сургуулиуд бий болгох асуудлыг цогц байдлаар шийдвэрлэхээр зорин ажиллаж байна. Энэ хүрээнд

- Ажил мэргэжлийн лавлахыг ажил олгогч, мэргэжлийн холбоодтой хамтран боловсруулдаг болоод байна.
- Мэргэжлийн боловсрол, сургалтын стандартыг баталж ЧСС-ыг стандартын дагуу зохион байгуулах нөхцлийг бүрдүүлээд байна.
- ЧСС-ын хөтөлбөрийн загварыг боловсруулснаар агуулгын хэт зөрүүтэй байдлыг багасгаж, суралцагчдыг ижил түвшинд бэлтгэх боломжийг бүрдүүлж байна.
- Мэргэшлийн түвшний үндэсний тогтолцоог бүрдүүлж байна. Ингэснээр иргэдийн мэргэжлийн ур чадварыг үнэлэх, чадамжийг түвшин бүрээр хөгжүүлэх, бүх нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн мэргэшлийн түвшинг тодорхойлох, холбогдох мэргэжлийн үнэмлэх, гэрчилгээ олгосноор иргэдэд ур чадвараа бодитой үнэлүүлж ур чадвартаа тохирсон цалин хөлс тогтоолгох, ажлын байртай болох, дараагийн шатны боловсрол эзэмших зэрэг ач холбогдолтой юм.

Сургалтыг ЧСС-д шилжүүлснээр тэргүүлэх салбарын 20 мэргэжлээр ажил мэргэжлийн лавлах, 35 мэргэжлийн ЧСС-ын хөтөлбөр боловсруулагдаж, сургалтад туршилтаар ашиглаж эхлээд байна (Хавсралт 1. ЧСС-ын хөтөлбөр болон ажил мэргэжлийн лавлахын жагсаалт).



3. НИЙГМИЙН ТҮНШЛЭЛ, ХАМТЫН АЖИЛЛАГАА САЙЖИРЧ БАЙНА.

Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 2009 онд хийсэн шинэчилсэн найруулгаар Мэргэжлийн боловсрол, сургалтын талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэхэд төр, хувийн хэвшлийн тэнцүү оролцоог хангасан Үндэсний зөвлөл байгуулж, тус зөвлөл нь МБС-ын дээд удирдлагыг хэрэгжүүлнэ гэж хуульчилсан. Мэргэжлийн боловсрол, сургалтын Үндэсний зөвлөлийн дүрэм, бүрэлдэхүүнийг (төр, хувийн хэвшлийн тэнцүү оролцоог 50:50 харьцаатай байхаар заасан) 2009 онд баталж хэрэгжүүлж эхэлсэн байна. Мөн салбарын хэмжээнд салбарын зөвлөл, орон нутгийн түвшинд аймаг, орон нутгийн зөвлөл, сургалтын байгууллагын түвшинд сургалтын удирдах зөвлөл зэрэг олон талын төлөөлөл бүхий нийгмийн түншлэлд тулгуурласан зөвлөл ажиллах эрх зүйн орчинг бүрдүүлсэн. Өнөөгийн байдлаар уул уурхай, барилга, авто зам, хүнсний үйлдвэрлэлийн салбар зөвлөлүүд байгуулагдсан байна.


Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөөр 50-иас дээш ажилтантай аж ахуйн нэгж суралцагчийн үйлдвэрлэлийн дадлагын ажлыг зохион байгуулж, удирдан чиглүүлэх үүрэг бүхий дадлагажуулагч багш ажиллуулна гэж томъёолсон нь дадлагын сургалтын чанарыг сайжруулахад ач холбогдолтой юм.

Сургалтын байгууллагын түвшинд нийгмийн түншлэл хамтын ажиллагааг өргөжүүлж, дадлагын сургалтын чанарыг сайжруулах зорилготой аж ахуйн нэгж байгууллага, суралцагч, сургууль гурван талт гэрээ байгуулан ажилладаг механизм бүрдээд байна.

4. МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ТОГТОЛЦООНЫ ШИНЭЧЛЭЛ

МБС-ын асуудал 2012 онд Хөдөлмөрийн яаманд харьяалагдах болсноор нийлүүлтэд суурилсан МБС-ын тогтолцооноос хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийгмийн түншлэлд суурилсан тогтолцоонд шилжих ажил эрчимжсэн. Үүнтэй холбоотойгоор 2016 оны МБС-ын тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөөр “Мэргэжлийн боловсрол, сургалтын тогтолцоо нь үндэсний зөвлөл, мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, үнэлгээ, мэдээллийн болон бүсийн арга зүйн төв, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагаас бүрдэхээр заасан.

Зураг 4. Мэргэжлийн боловсрол, сургалтын тогтолцоо



Мөн байгууллагуудын чиг үүрэг, түүнтэй холбогдон гарах дүрэм журмуудыг боловсруулах, шинэчлэх ажлууд хийгдэж байна.



5. ТӨГСӨГЧИЙН УР ЧАДВАР САЙЖИРЧ, ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ НЭМЭГДЭЖ БАЙНА

Сүүлийн жилүүдэд Мэргэжлийн боловсрол, сургалтын нэр хүнд өсч, элсэгчдийн тоо нэмэгдсэнээс гадна төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт жилээс жилд өсч байна. Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн 2015 оны үзүүлэлтийг 2009 онтой харьцуулахад 62,4% болж 20,9%-аар нэмэгдсэн³. Энэ нь төгсөгчдийн ур чадварыг нэмэгдүүлэх, ХЗЗ-ийн эрэлтэд нийцүүлэхтэй холбоотой хэрэгжүүлсэн зорилтот хөтөлбөр, арга хэмжээтэй салшгүй холбоотой. Тухайлбал:

- **Үндэсний мэргэжилтэй ажилтан бэлтгэх хөтөлбөр (2012-2014):** Ажил олгогчдын захиалгад тулгуурлан мэргэжилтэй ажилтныг бэлтгэж шууд ажлын байртай холбосон онцлогтой хөтөлбөр хэрэгжсэн. Үүний үр дүнд 150 орчим аж ахуйн нэгж байгууллага 4126 ажлын байрны захиалгыг өгч нийт 8417 иргэн хөтөлбөрт хамрагдсанаас 7137 иргэн шууд ажлын байраар хангагдсан байна.
- **Ажилтай орлоготой Монгол хүн хөтөлбөр (2013-2016):** Хөтөлбөр хэрэгжих хугацаанд салбарт нийт 49.7 тэрбум төгрөгийн улсын төсвийн хөрөнгө оруулалтыг хийж, давхардсан тоогоор 12 МБСБ-ын хичээлийн байр, дадлагын газар, дотуур байрны барилгыг шинээр барьж ашиглалтад оруулж, мөн давхардсан тоогоор 37 МБСБ-д шаардлагатай багц тоног төхөөрөмжийг нийлүүлэн мэргэжлийн боловсрол, сургалтын чанарыг дээшлүүлж, дадлагын орчин сайжруулсан. Мөн төрийн бус өмчийн 32 МБСБ-ын 40 мянган суралцагчийн тэтгэлэгт 13.6 тэрбум, хувьсах зардалд 15 тэрбум төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлсэн ба арга зүй, боловсон хүчний чадавхийг нь дэмжсэн сургалтад багш, удирдах ажилтнуудыг хамруулж шударга өрсөлдөх боломжийг дээшлүүлэн, сургалтын чанар, үр дүнд анхаарч ажилласан. Салбарын хэмжээнд 61.3 мянган суралцагчийг 193 мэргэжлээр элсүүлсний 62.8 хувь нь хөдөлмөрийн зах зээлд хамгийн өндөр эрэлттэй аж үйлдвэр, барилга, уул уурхайн чиглэлээр суралцаж, 60.7 мянган суралцагч төгссөний 66,3 хувь нь ажлын байртай болсон статистик тоон мэдээ байна.
- **“Дэлхийн ур чадвар”-ын тэмцээнд амжилттай оролцсон:** Монгол Улс 2014 онд Дэлхийн ур чадварын олон улсын байгууллагад гишүүнээр элсэн 2015 онд болох “Дэлхийн ур чадвар”-ын тэмцээнд багаа бэлтгэн оролцох болсны дагуу “Монгол ур чадвар” үндэсний тэмцээн салбарын багш, суралцагчдын дунд 9 мэргэжлээр 2013-2015 онд зохион байгуулагдаж давхардсан тоогоор 350 гаруй суралцагчид ур чадвараараа өрсөлдсөн. БНСУ, Тайвань, ОХУ-ын Эрхүү хотуудад дадлага хийж Монгол Улс 2015 онд анх удаа “Дэлхийн ур чадвар” 43 дахь удаагийн олон улсын тэмцээнд амжилттай⁴ оролцсон.

³ Мэргэжлийн боловсрол, сургалтын статистик мэдээлэл, 2015-2016 он

⁴ 2015 оны 43 дахь удаагийн “Дэлхийн ур чадвар”-ын тэмцээнд нийт 60 орны 1190 оюутан суралцагч 50 мэргэжлээр ур чадвараа сорьсон бөгөөд Монгол Улс баг анх удаа оролцон 42 дугаар байранд орж амжилт үзүүлсэн байна.



6. МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫН ОРЧИН САЙЖИРЧ БАЙНА.

Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн нийгэмд шилжсэн 1990 оны шилжилтийн үед төрийн өмчит үйлдвэрийн газрууд хаагдаж хумигдан мэргэжилтэй ажилтны эрэлт хэрэгцээ буурсан нь 15 мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагуудыг татан буулгахад хүрч, нийт МБСБ-уудын тоо 31 болж байв⁵. Тухайн үед сургах, суралцахуйн заах аргазүй хоцрогдож, тоног төхөөрөмж, барилга байгууламж нь хуучирч элэгдэн орчин үеийн хэрэгцээ шаардлагыг хангаж чадахгүй болсон байв.

Сүүлийн жилүүдэд ЧСС-ын шинэ аргазүйг нэвтрүүлэхтэй холбоотой сургалтын орчинг сайжруулах, шинэ дэвшилтэт техник, технологи, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх шаардлага гарсан.

МБС-ын байгууллагуудын сургалтын орчныг сайжруулахад 2010 оноос хойш 7 донор байгууллагуудын төсөл хэрэгжиж, нийт 44 сая ам.долларын хөрөнгө оруулалтыг сургалтын орчинг сайжруулахад зориулан 7 шинэ болон өргөтгөлийн барилга барих, 12 МБСБ-ын хичээл, дадлагын байрыг засварлах, давхардсан тоогоор 38 мэргэжлийн шинэ дэвшилтэт тоног төхөөрөмж нийлүүлэх ажлыг гүйцэтгэсэн байна. Үүнээс гадна төслүүдийн үйл ажилагааны хүрээнд мультимедиа сургалтын материал боловсруулах ажлыг өргөжүүлж, өндөр зэрэглэлийн зураг, дүрслэлтэй ном гарын авлага, техникийн англи хэлний толь бичиг, сурах бичиг 3D хичээл багтсан DVD багц сургалтын материал болон аудио бичлэгийн студийг нийлүүлсэн байна.

Олон улсын төсөл хөтөлбөрөөс гадна 2012 оноос хойш нийт 49.7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг улсын төсвөөс хийсэн байна. Энэхүү хөрөнгө оруулалтын 77.9% нь барилга угсралтын ажилд, 7.6% нь их засварын ажилд, 14.5% нь тоног төхөөрөмжийн шинэчлэлд тус тус зарцуулагджээ⁶.

МБС-ын гол цөм нь дадлагад суурилсан байдаг тул салбарын онцлогоос хамаарсан тоног, төхөөрөмж, мөн технологийн дэвшлийг байнга нэвтрүүлэхэд чиглэсэн их хэмжээний хөрөнгө оруулалтыг шаарддаг мэргэжилтэй ажилтан бэлтгэдэг боловсролын өвөрмөц салбар билээ. Энэ ч агуулгаараа сургалтын орчныг сайжруулахад багагүй хөрөнгө оруулалт хийж анхаарч ажилласны үр дүнд мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын орчин тодорхой түвшинд сайжраад байна.

⁵ Мэргэжлийн боловсрол, сургалтын тогтолцооны үүсэл, хөгжил, шинэчлэл, Эрдэм шинжилгээний бичиг, 2014 он, 94-р хуудас
⁶ Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр (2012-2016)-ийн 197.2 зорилтот ажлын биелэлт



1.4 САЛБАРЫН ТУЛГАМДСАН АСУУДЛУУД, ТЭДГЭЭРИЙН ШАЛТГААН

Мэргэжлийн боловсрол, сургалтын салбарт багагүй амжилт гарч, тодорхой үр дүнд хүрсэн хэдийч цаашид анхаарах, сайжруулах, шаардлагатай асуудлууд байсаар байна. Салбарын цаашдын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлоход тулгамдаж буй асуудлуудыг дараах байдлаар тодорхойлж байна. Үүнд:

1. САЛБАРЫН ТҮВШНИЙ СУДАЛГАА ХАНГАЛТГҮЙ, ХЭРЭГЛЭГЧДЭД ХҮРТЭЭМЖГҮЙ БАЙНА.

МБСБ-ууд, суралцагч, ажилчид, сургалтын орчны талаарх ерөнхий мэдээллийг агуулсан статистик тоо баримтыг Хөдөлмөрийн яам болон Үндэсний статистикийн хорооны баталсан маягтын дагуу бүх МБСБ-аас жил бүр тогтсон хугацаанд авч, тоон мэдээллийг Хөдөлмөрийн яамны вэб хуудас (www.mol.gov.mn), Статистикийн мэдээллийн нэгдсэн сан (www.1212.mn), ХЭҮСМҮТ-ийн вэб хуудас (<http://www.labornet.mn/>), Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн системүүдэд (<http://lmis.gov.mn/lmis>) байршуулдаг.

Хөдөлмөрийн яамны Мэргэжлийн боловсрол, сургалтын бодлого зохицуулалтын газраас статистик мэдээллийн эмхэтгэлийг хагас, бүтэн жилээр гаргаж байна. Мөн мэдээллийн нэгдсэн санг бий болгохоор сургалт удирдлагын (www.e-tvet.mn) мэдээллийн нэгдсэн системийг төрийн өмчийн МБСБ-уудад 2014 оноос эхлэн нэвтрүүлж байна.

Судалгаа шинжилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад дараах чиглэлээр анхаарч ажиллах хэрэгцээ шаардлага байна.

- Бодлого шийдвэр гаргахдаа судалгаа шинжилгээ, урт хугацааны прогноз бүхий тоо баримтад тулгуурлан хийх
- Тоон судалгаанаас чанарын судалгаа болгож хөгжүүлэх
- Судалгааг авах, боловсруулах үүрэг бүхий нэгж, албан тушаалтнуудыг чадавхижуулах
- Статистик, тоон мэдээллийг цуглуулах аргазүй, холбогдох маягтыг боловсронгуй болгож, цахим орчинг бүрдүүлэх

2. НИЙГМИЙН ТҮНШЛЭЛИЙГ БЭХЖҮҮЛЭХ, ҮР ДҮНТЭЙ ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХӨШҮҮРГИЙГ БИЙ БОЛГОХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.

Төр хувийн хэвшлийн түншлэлийг бэхжүүлэхэд салбар зөвлөлүүд, мэргэжлийн холбоод, ажил олгогчдын оролцоог нэмэгдүүлж үйл ажиллагааг дэмжин хөгжүүлэх шаардлагатай байна. Өнөөгийн байдлаар байгуулагдсан салбар зөвлөлүүдийн тогтвортой ажиллах нөхцөл бололцоо бүрдээгүйн улмаас үйл ажиллагаа нь зогсонги, шинэ салбар зөвлөл нэмэгдэхгүй байна. МБСҮЗ, түүний салбар зөвлөлүүд нь хуульд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлж чадахгүй байна. Тулгамдаж байгаа гол асуудал нь:

- МБС-ын Үндэсний зөвлөл, салбар зөвлөлүүдийг байгуулсан ч тэдний байнгын хэвийн үйл ажиллагааг хангах санхүүгийн хөшүүрэг байхгүй.
- Салбар зөвлөлүүд нь тодорхой санхүүжилт байхгүй тул үйл



ажиллагааг тогтмол хэрэгжүүлэх ажлын алба болон мэргэшсэн ажилтан байхгүй байна.

- Хувийн хэвшил, төсөл хөтөлбөрүүдтэй төрийн болон МБС-ын байгууллагуудын түвшинд хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлдэг ч мэдээлэл солилцох механизм сул, үр дүнг баталгаажуулах, түгээн дэлгэрүүлэх ажил үгүйлэгдэж байна.
- Салбарын нэр хүнд, ач холбогдлыг сурталчлан таниулах замаар хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх хэрэгтэй байна.

3. МЭРГЭШЛИЙН ТҮВШНИЙ ҮНДЭСНИЙ ТОГТОЛЦОО БҮРДЭЭГҮЙ БАЙНА.

Мэргэшлийн түвшний үндэсний тогтолцоо бүрдээгүй бөгөөд мэргэжил, түвшин бүрийн тодорхойлолтыг салбар зөвлөл, мэргэжлийн холбоод, ажил олгогчид хамтран тодорхойлох шаардлага мэргэжлийн боловсрол, сургалтын салбарт тулгарч байна. Мэргэшлийн түвшний үндэсний тогтолцоог хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлагыг дараах байдлаар харуулж байна. Үүнд:

- Иргэдийн эзэмшсэн мэргэжил нь олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдөж, энэ дагуу дотоод, гадаадад ажиллах, хөдөлмөрийн хөлсөө бодитоор үнэлүүлэх боломж хязгаарлагдмал байна.
- Өмнө эзэмшсэн мэдлэг, туршлагаа хүлээн зөвшөөрүүлэх, тэднийг насан туршдаа суралцах боломж олгох, дараагийн шатны сургалтад хамрагдах механизм бүрдээгүй байна.
- Техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалтын хөтөлбөр болон их дээд сургуулийн хөтөлбөр хооронд агуулгын залгамж холбоо байхгүй байна.
- Мэргэжлийн боловсрол, сургалтын үйл ажиллагаа нь салбар дундын зохицуулалттай, нийгмийн түншлэлд тулгуурлан мэргэшлийн түвшний үндэсний тогтолцоог хамтран хэрэгжүүлэх шаардлагатай байна.

4. МБС-ЫН ЧАНАРЫГ САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА

Мэргэжлийн болон техникийн боловсролсургалт, мэргэжлийн сургалтын бүхий л шатанд чанарын асуудлыг гол цөм болгон авч үзэх шаардлагатай байна. Нэн тэргүүнд мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага, мэргэшлийн чанарыг баталгаажуулах, холбогдох хууль эрх зүйн орчныг сайжруулан хэрэгжилтийг хангах хэрэгтэй. Одоогоор чанарын баталгаажилттай холбоотой дараах хүндрэл бэрхшээлүүд байна.

- Төгсөгчдийн ур чадвар (мэргэшил)-ийг үнэлэх, гэрчилгээжүүлэх механизм бүрэн төлөвшөөгүй
- МБС-ын байгууллагуудын өөрийн үнэлгээний болон дотоодын үнэлгээний шалгуур, стандарт, мэргэшсэн боловсон хүчин бүрдээгүй
- Чанарыг зөвхөн боловсролын магадлан итгэмжлэл буюу хөндлөнгийн үнэлгээний байгууллагаар сайн дурын үндсэн дээр гүйцэтгүүлж байна.
- Хүний нөөц, ажиллах хүчний ур чадварын шалгуур, үнэлгээний



тогтолцоо бүрдэж, төлөвшөөгүй байна. МБС-ын хөтөлбөрийн магадлан итгэмжлэл хангалтгүй байна.

5. ЧАДАМЖИД СУУРИЛСАН СУРГАЛТ, ҮНЭЛГЭЭНИЙ ТОГТОЛЦООГ ОЛОН УЛСЫН ЖИШИГТ НИЙЦҮҮЛЭН ХӨГЖҮҮЛЭХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.


Үйлдвэрлэл ажил, олгогчийн тодорхойлсон ажил мэргэжлийн лавлахын дагуу МБС-ын стандарт, хөтөлбөрийг үйлдвэрлэлийн технологийн дэвшилд тулгуурлан боловсруулах шаардлагатай байна. ЧСС-ыг тасралтгүй хөгжүүлэх чиглэлээр олон талт ажлууд хийгдэж байгаа ч дараах хүндрэл бэрхшээл байсаар байна. Үүнд:

- Ажил олгогчийн боловсруулсан ажил мэргэжлийн лавлах цөөн байна. Өнөөдөр салбарын хэмжээнд суралцагчид нийт 193⁷ мэргэжлээр суралцаж байгаа бөгөөд зөвхөн 20 ажил мэргэжлийн лавлах боловсруулагдсан байна.
- МБС-ын стандартын дагуу ЧСС-ын чадамжийн сан бүрдээгүйгээс сургууль бүр харилцан адилгүй сургалтын хөтөлбөрийг ашиглаж байна.
- ЧСС-ыг олон хувилбарт, уян хатан хэлбэрээр явуулж чадахгүй байна. Өөрөөр хэлбэл суралцагчдын суралцах хэрэгцээ, боломж нөхцөлд тохируулсан сургалтын арга хэлбэрүүд хязгаарлагдмал байна.
- Төгсөгчдийн ур чадварыг хөндлөнгийн үнэлгээгээр үнэлэх, баталгаажуулах үйл ажиллагаа бүрэн төлөвшөөгүй байна
- Ажил олгогчдын хэрэгцээнд нийцүүлэн элсэлтийг төлөвлөх, Төгсөгчдийн ур чадварыг сайжруулах шаардлага байна

МБС-ын төгсөгчдийн ур чадвар нь ЧСС-ын хөтөлбөр, багшийн ур чадвар, сургалтын орчин, дадлагаас ихээхэн хамаардаг. Ажил олгогчийн хэрэгцээ шаардлагыг хангах, мөнгэдний ажиллах хүчнийг орлох ур чадвартай мэргэжилтэй ажилтныг бэлтгэх хэрэгцээ байсаар байна. Тухайлбал, жилд дундажаар 27,5 мянган гадаад иргэн Монгол Улсад ажиллаж байна (Зураг 5). Гадаад ажилчдын дийлэнх хувь нь барилга, уул уурхайн салбарт ажиллаж байгаа нь (Зураг 6) гадны ажиллах хүчний импортыг бууруулж, дотоодын мэргэжилтэй ажилтнаар орлуулах хэрэгцээ шаардлага байгааг харуулж байна.




Зураг 5. Монгол улсад хөдөлмөр эрхэлсэн гадаадын иргэд (2011-2014 он)




Эх сурвалж: Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, судалгаа, мэдээллийн үндэсний төвийн тайлан, 2015 он

Зураг 6. Хөдөлмөр эрхлэх зөвшөөрөвлөсөн гадаад иргэд, эдийн засгийн салбараар /2014 он/



Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөх үйлчилгээг хөдөлмөрийн хэлтэс болон МБСБ-уудад нэвтрүүлж эхэлсэн. Гэсэн хэдий ч МБСБ-уудын төгсөгчдийн дийлэнх буюу 80% нь 14-20 насны залуучууд байна. Үүнээс 14-16 насны суралцагчид 40%-ийг эзэлж байгаа нь элсэгчид өөрийн сонирхолтой мэргэжлээ зөв сонгох, хөдөлмөрийн хүн болон төлөвших, амьдрах ухаанд суралцах хэрэгцээ, шаардлага байна.

Зураг 7. Суралцагчдын насны бүтэц, 2015-2016 оны хичээлийн жил



Эх сурвалж: Хөдөлмөрийн яам, МБС-ын 2015-2016 оны статистик мэдээлэл



6. СУРГАЛТЫН МАТЕРИАЛЛАГ ОРЧИН БА МЕНЕЖМЕНТИЙГ САЙЖРУУЛАХ ХЭРЭГЦЭЭ БАЙНА.

Мэргэжлийн боловсрол, сургалтын салбарт 1990-ээд онд ашиглаж байсан тоног төхөөрөмж, барилга байгууламж, тавилга, эд хогшил нь хуучирч элэгдэн орчин үеийн хэрэгцээ шаардлагыг хангаж чадахгүй байв. Энэхүү хуучирч хоцрогдсон арга барил, арга зүйг системээр нь өөрчлөн зохион байгуулах шаардлагын дагуу МБС-ыг чадамжид суурилсан сургалтын тогтолцоонд бүрэн шилжүүлэхээр зорилт тавин ажиллаж, улсын төсөв болон төсөл хөтөлбөрийн хүрээнд хөрөнгө оруулалт хийгдсэн ч салбарын хэмжээнд бүх сургуулийг мэргэжил бүрээр бүрэн хамарч чадаагүй байна.

Тухайлбал салбарт хэрэгжсэн томоохон төслийн нэг болох Монголын Мянганы Сорилтын Сангийн “Мэргэжлийн боловсрол, сургалт” төслийн хүрээнд сургалтын орчныг сайжруулахад 30 гаруй сая ам.доллар зарцуулагдсан ба нийт төрийн өмчийн 49 МБСБ-ын зөвхөн 28 нь төсөлд хамрагдан тодорхой хэмжээгээр тоног төхөөрөмжөөр хангагдсан байна. Үүнийг мэргэжлээр нь авч үзвэл нийт МБС-ын салбарт бэлтгэгддэг 193 мэргэжлийн 10 хүрэхгүй хувийг эзэлж байна⁸.

Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагуудын байр, хичээл, дадлагын ажилд шаардагдах тоног төхөөрөмж, техник хэрэгсэл муудсантай адил анги танхим, номын сангийн ширээ сандал, тавилга, соёл, спорт заалны тоног хэрэгсэл хуучирч, элэгдсэн байна.

Иймээс дадлагын сургалтыг голчлон чадамжид суурилсан сургалтыг зохион байгуулж байгаа мэргэжлийн боловсрол, сургалтад шинэ технологийг байнга нэвтрүүлэх, тоног төхөөрөмж, техник хэрэгслийг сайжруулах хэрэгцээ нь салбарын онцлогоос хамааран салшгүй асуудал болж байна.

Сургалтын байгууллагын менежмент, бүтэц зохион байгуулалтыг үндэсний, бүсийн, орон нутгийн бодлого, хөгжлийн чиг хандлагатай нийцүүлэн өөрчлөх шаардлага байна. Тухайлбал нийслэлийн болон орон нутгийн зарим сургалтын байгууллагад бэлтгэж байгаа мэргэжлүүдийг бүсчилсэн хөгжлийн бодлогод нийцүүлэн төрөлжүүлэх шаардлага байна. Үүнтэй холбоотой сургалтын байгууллагуудыг төрөлжүүлэх, нөөцийн оновчтой хувиарлалт хийх шаардлага байна. Зураг 8 харна уу.

Шигтгээ 2.


Сургалтын байгууллагыг төрөлжүүлэх нь ямар ач холбогдолтой вэ?

Сургуулиудыг төрөлжүүлснээр сургалтын байгууллагыг улсын болон бүс нутгийн хөгжлийн эрэлттэй илүүтэй холбох, багш нарыг мэргэшүүлэх, дадлагын техник, тоног төхөөрөмжийг төрөлжүүлж бэхжүүлэх, сургалтын байгууллага дундын үйлдвэрлэлийн дадлагын чанартай, иж бүрэн баазыг буй болгож ашиглах замаар сургалт, дадлагын сургалтыг чанаржуулах, хөрөнгө оруулалтыг оновчтой шийдэх боломж өргөжинө. Мөн сургалтын байгууллагууд ижил мэргэжлээр элсэлт авахыг хязгаарлаж, ХЗЗ-ийн эрэлттэй уялдуулах, төгсөгчийн мэргэжлийн ур чадварыг ахиулахгэх мэт олон суурь асуудлуудыг үр дүнтэй шийдвэрлэх боломж бүрдэх болно (Мэргэжлийн боловсрол сургалт, түншлэл⁴ ТББ).

⁸ “Мэргэжлийн боловсрол, сургалтын салбарт Мянганы сорилтын сангийн буцалтгүй тусламжийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх дараагийн шатны төслийн санал” Хөдөлмөрийн яам, 2015 он



Зураг 8. МБС-ын байгууллагуудын бэлтгэж буй мэргэжлийн чиглэл, бүсээр



Эх сурвалж: Хөдөлмөрийн яам, МБС-ын 2015-2016 оны статистик мэдээлэлд үндэслэн боловсруулав


МБСБ-уудыг зургаан бүсэд ангилдаг бөгөөд тэдгээрийн мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалт явуулж буй мэргэжлүүдийг салбараар нь ангилж харахад барилга, аж үйлдвэрийн салбарын мэргэжил зонхилж байна.



7. ХҮНИЙ НӨӨЦИЙГ ТАСРАЛТГҮЙ ХӨГЖҮҮЛЭХ ТОГТОЛЦОО БИЙ БОЛГОХ ХЭРЭГЦЭЭТЭЙ БАЙНА

Мэргэжлийн боловсрол, сургалтын салбарт 2015-2016 оны хичээлийн жилд нийт 4520 хүн ажиллаж байгаагийн 55.4% буюу 2504 үндсэн багш нар байна. Үндсэн багш нарын 68,1% (1704) нь мэргэжлийн багш, 31.9% (800) нь ерөнхий эрдмийн багш нар байна (Зураг 7).

Зураг 9. МБСБ-ын хүний нөөц, үндсэн багш нарын бүтэц



Эх сурвалж: Хөдөлмөрийн яам, МБС-ын 2015-2016 оны статистик мэдээлэл

Мэргэжлийн багш нарын хувьд 2015 оны байдлаар 91% нь бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй, мастер ба ахлах зэрэгтэй багш 13,1%, үйлдвэр аж ахуй нэгжид ажиллаж байсан туршлагатай багш 16,7%-ийг эзэлж байна. Иймээс багшийг мэргэшүүлэх, ур чадварыг дээшлүүлэх, улмаар үйлдвэр аж ахуй нэгжид ажиллаж байсан туршлагатай инженерүүдийг МБС-ын салбарт татан оролцуулах хэрэгцээ шаардлага байна.

Салбарын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх үйл ажиллагаа нь шинээр бэлтгэх, мэргэшүүлэх гэсэн хоёр хэлбэртэй байна. Монголын МБС-ын салбарын багшийг шинээр бэлтгэх болон тасралтгүй мэргэшүүлэх тогтолцоо байхгүй байна. Доорх хүснэгтэнд багш нарыг хэрхэн бэлтгэж, мэргэжил дээшлүүлдэг өнөөгийн нөхцөл байдлыг тоймлон харууллаа. Үүнд:



Хүснэгт 1. Салбарын багшийг хөгжүүлэх тогтолцооны өнөөгийн байдал

Орчин, нөхцөл	Багш шинээр бэлтгэх	Багшийг мэргэшүүлэх
Хууль эрхзүй	<p>18.1 Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын багш нь бакалавр, түүнээс дээш зэрэгтэй, эсхүл үйлдвэрлэлийн ажлын зохих дадлагатай, мэргэжлийн өндөр зэрэгтэй, багшлах эрхтэй байна.</p> <p>18.2 Мэргэжлийн сургалтыг хөтлөн удирдах багш нь үйлдвэрлэл, технологийн туршлагатай, мэргэжлийн өндөр зэрэгтэй, багшлах эрхтэй байна.</p> <p>18.3.Багшийн мэргэжил эзэмшээгүй орон тооны багш нь сургалтын заах арга зүй эзэмшиж, багшлах эрхийн үнэмлэх авсан байна.</p>	<p>Мэргэжлийн багш нь боловсролын хуульд тусгагднаас гадна дараах эрхтэй</p> <p>19.1.1.үйлдвэрлэл, үйлчилгээний байгууллагад мэргэжлийн дагуу гэрээгээр ажиллах, мэргэшил дээшлүүлэх, зөвлөгөө өгөх эрхтэй</p> <p>19.1.2.шинэ техник, технологи судлах, дадлага хийхэрхтэй;</p> <p>19.1.3.бүтээлийн чөлөө авах эрхтэй</p> <p>19.2.3.шинэ техник, технологи, стандарт, норматив, хөдөлмөр зохион байгуулалтын дэвшилтэт арга барил судлах, сургалтандаа эдгээрийг хэрэглэх үүрэгтэй</p>
Санхүүжилт	Улсын төсвийн хөрөнгөөр багш бэлтгэхэд зориулсан санхүүжилт буюу зардлын зүйл анги байдаггүй	Төсөл хөтөлбөрүүдийн хүрээнд багшийн мэргэжил дээшлүүлэх үйл ажиллагааг тухайн үеийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн ихэвчлэн богино хугацаагаар зохион байгуулж байна.
Бодлого, шийдвэр	2012-2015 оны хооронд Агентлагийн даргын тушаалаар Мастер багшийг бэлтгэх тушаалыг гаргаж, холбогдох хөтөлбөр төлөвлөгөөг боловсруулан Оюу Толгой ХК-ын дэмжлэгтэйгээр хэрэгжүүлсэн.	<p>2015 онд 'Мэргэжлийн боловсрол, сургалтын багшийн хөгжил' хөтөлбөр боловсруулагдан, хэрэгжүүлж эхлээд байна.</p> <p>2016-2020 онд жил бүр 500-аас доошгүй багшийг мэргэшүүлсэн байна гэсэн зорилт тавьсан</p>

Хүний нөөцийг мэргэшүүлэх сургалт явагдаж байгаа ч тасралтгүй хөгжүүлдэг тогтолцоо, институт байхгүй байгаа нь багшийн хөгжилтэй холбоотой хуулийн заалтыг тэр бүр хангаж ажиллаж чадахгүй байна. МБС-ын тогтолцоо сайтай улс орнуудын хувьд багш, удирдлагыг тасралтгүй хөгжүүлэх нөхцлийг хангасан бие даасан институт буюу дэд бүтцийг бий болгосон байдаг. Жишээ нь. БНСУ-д “Дэвшилтэт технологийн төв”-ийг байгуулж, багш нараа шинэ технологид сургадаг бол Австрали улсад Үйлдвэрийн инженерүүдийг шинэ багшаар бэлтгэх тогтолцоотой.

8. МБС-ЫН САНХҮҮЖИЛТИЙН ТОГТОЛЦОО СУЛ БАЙНА.

МБС-ын салбарын хөрөнгө оруулалт нь Засгийн газраас, тусгай сангаас, хөгжлийн хөтөлбөрүүдээс, аж ахуйн нэгж байгууллагаас гэсэн 4 үндсэн хэлбэртэй байна. Төрийн өмчийн МБСБ-уудын хувьд улсын төсвийн санхүүжилтээс гадна өөрийн үйл ажиллагаа, түншлэлийн хэлбэрээр орлого олох боломжтой ч түүнийг захиран зарцуулах эрх хаалттай байна. Уг асуудлыг МБС-ын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах замаар МБСБ орлого олох, зарцуулах, тайлагнах эрхийг хангахаар шийдвэрлэн ажиллаж байна. Мөн МБСБ-ыг нэг суралцагчид оногдох хувьсах зардлаар тооцон санхүүжүүлж байна. Энэ



нь дадлагын сургалтын өртөг өндөр мэргэжлээр сургалт явуулахад хүндрэл үүсгэдэг төдийгүй, сургалтын байгууллагын хувьд бодит санхүүжилт болж чадахгүй байна. Салбарын санхүүжилтийг шийдвэрлэхэд дараах хүндрэлүүд гарч байна.

- МБС-ын байгууллагын үр дүн, гүйцэтгэлд суурилсан санхүүжилт хийгдэхгүй байгаа нь сургалтын байгууллагуудын өрсөлдөх чадвар, чанарыг сайжруулах хөшүүрэг болж чадахгүй байна.
- Хичээл сургалтын зардлыг нэг суралцагчид оногдох хувьсах зардлаар тооцдог нь өртөг өндөр нарийн мэргэжлээр сургалт явуулах боломжгүйд хүргэдэг.
- Санхүүжилтийн бодит бус байдал нь сургалтын байгууллагуудыг материаллаг орчин болон менежментийг сайжруулахад хангалттай бус байна.
- Санхүүгийн олон эх үүсвэрийг бий болгох, ялангуяа ажил олгогчийн оруулах хувь нэмрийг МБС-ыг дэмжих санд төвлөрүүлэх дахин хувиарлах, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах шаардлагатай байна.
- Салбарын санхүүжилт, хөрөнгө оруулалт, тэдгээрийн зарцуулалтын талаарх тоон мэдээллийг нэгдсэн байдлаар харуулсан судалгаа, тооцоо хангалтгүй байхгүй байна.



МЭРГЭЖЛИЙН БОЛОН ТЕХНИКИЙН БОЛОВСРОЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХҮРЭХ ГОЛ ҮР ДҮН



2016 он

- ▶ МБС-ын салбарын, орон нутгийн, сургалтын байгууллагын зөвлөлийн үйл ажиллагааны уялдаа холбоог хангах судалгаа хийгдэнэ.
- ▶ ААН байгууллага, мэргэжлийн холбоодтой үр дүнтэй хамтран ажиллах зөвлөмж гарна.

2017 он

- ▶ МБС-ын түншлэлийг хөгжүүлэх, салбар дундын зохицуулалтыг хангах дэд хөтөлбөр боловсруулагдсан байна.
- ▶ МБС-ын салбарын талаар олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх сурталчилгааны ажлын төлөвлөгөө боловсруулагдсан байна.

2017-2020 он

- ▶ МБС-ын салбарын, орон нутгийн, сургалтын байгууллагуудын салбар зөвлөлийн үүрэг хариуцлагыг тодорхойлж, чадавхи бэхжүүлэх, үйл ажиллагааг дэмжинэ.

2017-2021 он

- ▶ ААН-ийн дадлагажуулагч багш, хөндлөнгийн үнэлгээний ажилтныг бэлтгэнэ.

2016 он

- ▶ “Мэргэшлийн түвшний Үндэсний тогтолцоо”-ны загвар боловсруулагдсан байна.
- ▶ Ажил мэргэжлийн лавлах боловсруулах тэргүүлэх чиглэлийн мэргэжлүүд тодорхойлогдоно.
- ▶ МТҮТ-г олон нийтэд сурталчлах ажлын төлөвлөгөө гарна.

2017 он

- ▶ Албан бус боловсрол, ажил амьдралын туршлагаас олж авсан мэдлэг, ур чадварыг хүлээн зөвшөөрөх, тогтолцоо бүрдэнэ.

2018 он

- ▶ Төгсөгчдийн бичиг баримтын бүртгэл мэдээллийн сан бий болсон байна.

2016 он

- ▶ МБС-ын чанарын баталгаажилтын хамрах хүрээ, хэрэгжүүлэгч байгууллага тодорхойлогдсон байна.
- ▶ Хөндлөнгийн хяналт хийхтэй холбоотой дүрэм, журам боловсруулагдсан байна.
- ▶ ҮМТ, БАЗТ-ийн арга зүйчдийг чадавхжуулах сургалтын хэрэгцээ тодорхойлогдоно.
- ▶ Салбарт ашиглах мэдээллийн сангийн агуулга, хамрах хүрээ, төрлийг тодорхойлно.
- ▶ Байгууллагын менежментийн ногоон хөгжлийн бодлого, олон улсын стандартуудыг судлана.
- ▶ Элсэлтийг төлөвлөх үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийнэ.
- ▶ МБСБ-ыг төрөлжүүлэх нөхцөл байдлын судалгаа хийгдэнэ.

2017 он

- ▶ МБСБ-ын хэв шинж нэг бүрээр шалгуур үзүүлэлтийг тодорхойлсон байна.
- ▶ Үнэлгээний ажилтан, салбарын шинжээч нарт тавигдах шаардлагыг тодорхойлох, сургалтын хөтөлбөр боловсруулагдана.
- ▶ e-tvet.mn мэдээллийн сангийн ашиглалтыг сайжруулна.
- ▶ МБСБ-ыг төрөлжүүлэх үндсэн чиглэл боловсруулагдана.

2018 он

- ▶ 2017-2018 онд МБС-ын чанарын баталгаажилтын талаар гарын авлага боловсруулагдаж, сургалт зохион байгуулагдана.
- ▶ Үнэлгээний ажилтнууд салбарын шинжээчдийг сонгож бэлтгэнэ.

ЗОРИЛТ-1

НИЙГМИЙН ТҮНШЛЭЛ, ХАМТЫН АЖИЛЛАГААГ ӨРГӨЖҮҮЛЭХ, САЛБАРЫН НЭР ХҮНДИЙГ ӨСГӨХ

ЗОРИЛТ-2

МЭРГЭШЛИЙН ТҮВШНИЙ ҮНДЭСНИЙ ТОГТОЛЦООГ ТӨЛӨВШҮҮЛЭХ

ЗОРИЛТ-3

ЧАНАРЫН БАТАЛГААЖУУЛАЛТ, БАЙГУУЛЛАГЫН МЕНЕЖМЕНТ, ЗАСАГЛАЛЫГ САЙЖРУУЛАХ

2021 он

- ▶ 4 шинэ салбар зөвлөл байгуулагдаж, үндэсний хэмжээнд 8 салбар зөвлөлтэй болсон байна.
- ▶ Ажил олгогч, хувийн хэвшлийн байгууллагын оролцоо 60% болж нэмэгдсэн байна.
- ▶ МБС-ын салбарын талаарх олон нийтийн ойлголт, мэдлэг 2016 оноос 30 хувиар нэмэгдсэн байна.

2016-2021 он

- ▶ МТҮТ-г олон нийтэд сурталчлах сурталчилгааны ажил тасралтгүй, үе шаттайгаар хийгдэнэ.

2021 он

- ▶ ҮМТ-д 100-аас доошгүй иргэн албан бус боловсролоо үнэлүүлж, гэрчилгээ авсан байна.
- ▶ 73,000 гаруй төгсөгч Мэргэжлийн үнэмлэх, гэрчилгээ авсан байна.
- ▶ 40 мэргэжлээр ажил мэргэжлийн лавлах боловсруулагдана.

2018 он

- ▶ ҮМТ дээр байрлуулах мэдээллийн сангуудыг ашиглалтанд оруулна.
- ▶ Ногоон хөгжил, тогтвортой хөгжлийн ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх сургалт зохион байгуулагдана.
- ▶ Элсэлтийг ХЗЗ-ийн эрэлт, орон нутгийн онцлогт тохируулан төлөвлөх, төгсөгчдийн мөшгөх судалгааг хийх талаар чадавхи бэхжсэн байна.

2019 он

- ▶ МБС-ын чанарын баталгаажилтын талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд дүгнэгдэж сайжруулалт хийгдсэн байна.
- ▶ Тээврийн хэрэгслийн жолооч жолооч бэлтгэх сургалтын бүртгэл, мэдээллийн санг сайжруулна.

2021 он

- ▶ 2019-2021 онд ҮМТ, БАЗТ-ийн арга зүйчид салбарын чанарын баталгаажилтыг ханган ажиллаж, мэргэшсэн үнэлээчдийн тоо 45 болсон байна.
- ▶ Нийт 81 МБСБ-ыг хөндлөнгийн үнэлгээнд хамруулна.
- ▶ 20 МБСБ, 15 ЧСС-ын хөтөлбөр магадлан итгэмжлэгдсэн байна.
- ▶ Салбарын түвшинд сургалт удирдлагын нэгдсэн мэдээллийн систем (e-tvet.mn) нэвтэрч, тогтвортой ашиглагдах мэдээллийн сангуудтай болсон байна.
- ▶ ХЗЗ-ийн эрэлт, орон нутгийн онцлогт тохируулсан элсэлтийг зохион байгуулж, төгсөгчдийн 70%-ийг ажлын байртай болгоно.
- ▶ Төрөлжсөн МБСБ-ын тоо 6 болсон байна.



2016 он

- ▶ Чадамжийн сан үүсгэх цахим орчныг бүрдүүлэх судалгаа хийгдэнэ.
- ▶ Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хэрэгцээнд нийцсэн МБС-ын чиглэлийг тодорхойлох судалгаа хийгдэнэ.
- ▶ Тоног төхөөрөмж, техник хэрэгсэл нийлүүлэх төлөвлөгөө боловсруулна.
- ▶ ЧСС-д шаардлагатай иж бүрэн багц материалыг тодорхойлж, удирдамж боловсруулагдсан байна.
- ▶ ЧСС-ын хувилбарт хөтөлбөрүүдийг тодорхойлж, төлөвлөгөө гаргана.

2017 он

- ▶ ЧССУ-ний аргагүй удирдамж боловсруулагдсан байна.
- ▶ ҮМТ-д цахим чадамжийн сан бий болсон байна.
- ▶ Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөхүүдийг бакалаврын түвшинд бэлтгэж эхэлнэ.

2018 он

- ▶ ҮМТ-д цахим чадамжийн сан бий болсон байна.
- ▶ Ажил мэргэжлийн чиг баримжаа болон зөв хандлага, төлөвлөлийг олгох хөтөлбөр, арга зүйтэй болсон байна.

2016 он

- ▶ Хүний нөөцийн хангамж, нийгмийн хамгаалал, хөгжүүлэлтийн судалгаа хийгдэнэ.
- ▶ "Монгол ур чадвар" тэмцээнүүд зохион байгуулагдсан байна.

2017 он

- ▶ МБС-ын багш, удирдах ажилтны мэргэшлийн түвшинг тодорхойлсон байна.
- ▶ "МБС-ын удирдах ажилтны хөгжил" хөтөлбөр 2017-2021 боловсруулагдаж, хэрэгжинэ.
- ▶ Багшийг хөгжүүлэх сургалтын байгууллагад тавигдах шалгуур болон хөтөлбөр боловсруулагдана.
- ▶ "Дэлхийн ур чадвар-2017" тэмцээнд оролцсон байна.

2018 он

- ▶ МБСБ-ын багш, удирдах ажилтнуудын мэргэшлийн түвшинд үндэслэн цалин хөлсийг тодорхойлно.

2019 он

- ▶ "Дэлхийн ур чадвар-2019" тэмцээнд оролцсон байна

2016 он

- ▶ Салбарын Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн донор байгууллагуудын зохицуулалт хийгдсэн байна.
- ▶ МБСБ өөрийн үйл ажиллагаанаас орлого олох, зарцуулах, тайлагнах журам баталгаажсан байна.

2017 он

- ▶ МБС-ын байгууллагуудыг мэргэжлийн өөрийн өртөгт суурилан санхүүжүүлэх арга аргачлалыг боловсруулсан байна.
- ▶ МБС-ыг Дэмжих сангийн журам шинэчлэн боловсруулагдаж, мөрдөгдөнө.

2018 он

- ▶ 2-3 мэргэжлээр өөрийн өртөгт суурилсан санхүүжилтыг туршилтаар гүйцэтгэнэ.

ЗОРИЛТ-4

ЧАДАМЖИД СУУРИЛСАН СУРГАЛТ, ҮНЭЛГЭЭНИЙ ТОГТОЛЦООГ ТӨЛӨВШҮҮЛЭХ

ЗОРИЛТ-5

САЛБАРЫН ХҮНИЙ НӨӨЦ, УДИРДЛАГА, БАГШИЙН ХӨГЖЛИЙГ ТАСРАЛТГҮЙ ХАНГАХ, ЧАДАВХИЙГ

ЗОРИЛТ-6

САНХҮҮЖИЛТИЙН ТОГТОЛЦООГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ

2021 он

- ▶ ЧССУ-ний арга зүйг 30 МБСБ нэвтрүүлсэн байна.
- ▶ 50 мэргэжлийн стандарт, ЧСС-ын хөтөлбөр боловсруулагдсан байна.
- ▶ 20 МБС-ын хөтөлбөрийн агуулга, багц цагийг бакалаврын боловсролын хөтөлбөрт дүйцүүлсэн байна.
- ▶ ҮМТ-д байрших чадамжийн санд нийт 20 мэргэжлийн мэдээллийг оруулсан байна.
- ▶ Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан 5 мэргэжлийн анги нээсэн байна.
- ▶ Нийт 20 мэргэжлийн сурах бичиг, гарын авлагыг боловсруулж, хэвлүүлсэн байна.
- ▶ Бус бүрт бизнес инкубатор төв байгуулагдан нийт төгсөгчдийн 90 ААНБ-ыг бойжуулсан байна.
- ▶ 26 мэргэжлийн тоног төхөөрөмж, техник хэрэгслийг зорилтот МБСБ-уудад нийлүүлнэ.
- ▶ МБС-ын салбарт суралцагчдын тоо 60.000-д хүрсэн байна.

2018-2021 он

- ▶ "Мэргэшлийн түвшинтэй уялдуулан багш, удирдах ажилтанг үнэлэх, гэрчилгээжүүлэх ажил хийгдэнэ.

2021 он

- ▶ "Мэргэжлийн боловсрол, сургалтын багшийн хөгжил" 2015-2020 хөтөлбөрийн хэрэгжилт 90%-иас дээш биелсэн байна.
- ▶ Багшийг сургаж хөгжүүлэх шаардлага хангасан 5-аас доошгүй байгууллагатай болсон байна.
- ▶ Багш, инженер техникийн ажилтнуудын солилцооны хөтөлбөр хэрэгжиж нийт 700 гаруй багш ур чадвараа дээшлүүлсэн байна.
- ▶ "Дэлхийн ур чадвар-2021" тэмцээнд оролцсон байна
- ▶ МБСБ-ын инноваци, эрдэм шинжилгээний ажил эрхлэх чиглэлээр 300-аас доошгүй хүнийг сургасан байна.
- ▶ МБС-ын салбарын 10-аас доошгүй инновацийн бүтээлд оюуны өмчийн эрхийг авсан байна.

2021 он

- ▶ Төсөл хөтөлбөрийн уялдааг хангасан бодлого, төлөвлөлт сайжирсан байна.
- ▶ Мэргэжлийн өөрийн өртөгт суурилсан санхүүжилтийг нэвтрүүлсэн МБСБ-ын тоо 5-аас дээш байна.
- ▶ МБСБ-ын өөрийн үйл ажиллагаанаас олох орлого нэмэгдсэн байна.
- ▶ 4 салбарын ААНБ-ын цалингийн сангаас дэмжих санд орлогыг төвлөрүүлсэн байна.



ХОЁР. МБС-ЫН САЛБАРЫН ДУНД ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГО ЗОРИЛТ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

АЛСЫН ХАРАА

Мэргэжлийн болон техникийн боловсролсургалтыг бүс нутгийн болон үндэсний түвшинд хүлээн зөвшөөрөгдөхүйц Монгол Улсын эдийн засаг, нийгмийн тогтвортой хөгжлийн хөдөлгөгч хүч болгон хөгжүүлэх

ЭРХЭМ ЗОРИЛГО

Мэргэжлийн мэдлэг, ур чадвар, соёл, төлөвшлийн хувьд олон улсад хүлээн зөвшөөрөгдөхүйц, үнэ цэнэтэй үндэсний мэргэжилтэй ажилтныг бэлтгэх, мэргэшүүлэх, ур чадварыг тасралтгүй хөгжүүлэх замаар эдийн засаг, нийгмийн тогтвортой хөгжилд бодитой хувь нэмэр оруулна.

ҮНЭТ ЗҮЙЛ

- Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн байх
- Чанар, үр ашигтай байх
- Тогтвортой хөгжлийг баримжаалах
- Насан туршийн боловсролыг дэмжсэн байх
- Нийгмийн түншлэлд түшиглэх
- Суралцагчдын эрх, оролцоог хангах
- Тэгш, хүртээмжтэй байх

Салбарын оролцогч талуудын санал, Засгийн газрын бодлого, чиглэлд нийцүүлэн Мэргэжлийн болон техникийн боловсролыг 2016-2021 онд хөгжүүлэх Үндэсний хөтөлбөрт дараах зорилго, зорилтыг дэвшүүлээ.

2.1 ЗОРИЛГО

Монгол Улсын хөгжлийн бодлого, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, шаардлагад нийцсэн, иргэдийн хэрэгцээ, авъяас, сонирхолд тохирсон мэргэжлийн болон техникийн боловсролыг шинэчлэн хөгжүүлж, чанар, хүртээмж, үр өгөөжийг дээшлүүлнэ.

2.2 ЗОРИЛТУУД

1. Нийгмийн түншлэл, хамтын ажиллагааг өргөжүүлэх, салбарын нэр хүндийг өсгөх;
2. Мэргэжлийн түвшний үндэсний тогтолцоог төлөвшүүлэх;
3. Чанарын баталгаажуулалт, байгууллагын менежмент засаглалыг сайжруулах;
4. Чадамжид суурилсан сургалт, үнэлгээний тогтолцоог төлөвшүүлэх;
5. Салбарын хүний нөөц, удирдлага, багшийн хөгжлийг тасралтгүй хангах, чадавхийг бэхжүүлэх;
6. Санхүүжилтийн тогтолцоог боловсронгуй болгох;

Зорилт нэг бүрийн тодорхойлолт, ач холбогдлыг Хүснэгт 2-оос харна уу.

2.3 БАРИМТЛАХ ЗАРЧИМ

- ✓ Монгол улсын нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэл, боловсрол, хөдөлмөр эрхлэлт болон бусад салбарын бодлогуудтай нягт уялдуулах;
- ✓ Ажил олгогч, төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, сургалтын байгууллага, суралцагч зэрэг оролцогчдын зохистой түншлэл, оролцоог хангах;
- ✓ Мэдээллийн нээлттэй байдал, тогтмол хяналт-шинжилгээ, үнэлгээ, нотолгоонд суурилсан тасралтгүй, уян хатан үйл ажиллагааг харилцан уялдаатай авч үзэж, эргэх холбоог сайжруулах;

16 МБС-ын хүний нөөцийн чадамжийн хүрээ (Competence frameworks for TVET professionals) нь багш, сургагч болон удирдлагуудад шаардлагатай ур чадвар, мэдлэг, чадамжуудын тодорхойлолт юм. Энэхүү чадамжийн хүрээг боловсруулснаар багшийн хөгжлийн талаар бодлого боловсруулах, арга хэмжээ авахад төр засгийн байгууллагад ач холбогдол өгөхөөс гадна тухайн багш, ажилтнуудын хувьд хийж буй ажилдаа анхаарах, өөртөө илтгэлтэй байх, өсч хөгжих нөхцлийг бүрдүүлдэг. Ингэхдээ, тухайн мэргэжлийн салбарт багшийн чадамж, аргазүйг үнэлж, гэрчилгээжүүлэх эрх бүхий салбарын мэргэисэн үнэлгээч нарыг бэлтгэх замаар хэрэгжүүлнэ (UNEVOC, Transforming TVET page 113).

Хүснэгт 2. Үндсэн зорилтууд, тэдгээрийн ач холбогдол, анхаарах асуудал

Зорилт	Үйл ажиллагааны цар хүрээ, тодорхойлолт	Ач холбогдол, давуу тал	Анхаарах асуудал
1	<p>Нийгмийн түншлэлийг ажил олгогч, үйлдвэрчний эвлэл, төрийн байгууллагууд болон бусад (жишээ нь: сайн дурын ажилчид, суралцагчид, олон нийт гэх мэт) төлөөллийг хамарсан гурав эсвэл олон талт хамтын ажиллагаа гэж тодорхойлох боломжтой.</p>	<ul style="list-style-type: none"> • Хөгжил, шинэчлэлийн төлөө үүрэг хариуцлагаа хуваалцана • Хамтран хэлэлцэж, зөвшилцөх, санхүү болон хөрөнгөө нийлүүлэх замаар харилцан үр өгөөжтэй ажиллана • Гишүүд харилцан бие биенээсээ суралцах, мэдлэгээ дээшлүүлнэ. • Суралцагч, төгсөгчид дадлага хийх, ажлын байраар хангагдана. 	<p>Гишүүдийн аль нэг нь давамгайлсан бус түншүүдийн тэгш оролцоог хангах нь чухал. Мөн хамтын ажиллагаанд бүх оролцогч тал/түншүүдийн идэвхитэй оролцоотой байх.</p>
2	<p>Мэргэшлийн түвшний үндэсний тогтолцоо нь түвшин бүрээр харгалзах мэргэшлүүдийг хүснэгтэнд шатлан харуулсанг хэлнэ. Ингэснээр тухайн улс орны мэргэшлүүдийг нэтгэн харах боломжийг бий болгодог төдийгүй тэдгээр мэргэшлүүдийн харилцан уялдаа болон сургалтын байгууллагын ахиц дэвшил, залгамж холбоог харуулж өгдөг.</p>	<ul style="list-style-type: none"> • Мэргэшлийн талаар сургалтын байгууллагууд, ажил олгогч, суралцагчдын дунд нэгдмэл нэг ойлголттой болно • Ялгаатай мэргэшлүүдийг илүү хялбар, ойлгомжтой болно. • Улс орны мэргэшлүүдийг нэгтгэж нэг хүрээнд дүрслэн оруулснаар мэргэшлүүдийн хоорондын харилцан уялдаа болон ахиц дэвшил илүү ойлгомжтой хялбар болно. 	<p>Сургалтын байгууллагууд, ажил олгогч болон суралцагч зэрэг талуудыг өргөн хүрээнд хамруулах. Сургалтын агуулгын залгамж холбоо, мэргэшлийн ахиц дэвшлийг ойлгомжтой тодорхойлохын тулд ерөнхий боловсрол, дээд боловсрол, мэргэшлийн боловсрол зэрэг боловсролын төлөөллийг зайлшгүй оролцуулах ёстой.</p>
3	<p>МБС-ын чанарын баталгаажилтыг үндэсний түвшинд, зөв зохион байгуулснаар хөдөлмөрийн зах зээл, ажил олгогч болон суралцагчдын эрэлт хэрэгцээг хангах гол үндэслэл болно.</p>	<ul style="list-style-type: none"> • Ажил олгогчид, суралцагчид хоёул МБС-аар олгогдож буй мэргэшилд итгэл үнэмшилтэй болж, улмаар үнэ цэнэ нэмэгдэнэ. • Чанаргүй сургалтын үйл ажиллагаа багасна • Төгсөгчдийн ур чадвар ажил олгогчдын эрэлт хэрэгцээнд илүүтэй нийцнэ. 	<p>Чанарын баталгаажуулалтын үндэсний тогтолцоо зайлшгүй оршиж байх ёстой бөгөөд – ингэснээр төгсөгчдийн ур чадварыг харьцуулах боломжтой болно. Өөрөөр хэлбэл нэг сургалтын байгууллагын төгсөгчийн ур чадварыг нөгөө сургуулийн төгсөгчийн ур чадвартай жишихүйц байна.</p>





4	<p>Чадамжид суурилсан сургалт, үнэлгээ нь тухайн хүн сургалтанд хамрагдсаны дараа эзэмшвэл зохих ур чадваруудыг олгоход чиглэдэг. Өөрөөр хэлбэл үр дүн буюу гарц дээр тулгуурладаг, тухайлбал 2 жилийн сургалтын хөтөлбөрт хамрагдсан гэхээсээ илүүтэй эзэмшсэн мэдлэг, ур чадвар, хандлагаа батлан харуулдаг үйл явц юм.</p>	<ul style="list-style-type: none"> • Ажил олгогчийн хэрэгцээнд тулгуурласан ба ажил мэргэжлийн лавлах (стандарт)-ын дагуу ажил гүйцэтгэх ур чадварыг олгоход чиглэнэ. • Хувь хүний хэрэгцээнд нийцүүлж хөтөлбөр болон суралцах хугацааны хувьд уян хатан. • Үнэлгээ нь өөрийн гүйцэтгэл дээр тулгуурладаг ба хугацааны хувьд тасралтгүй шинж чанартай. 	<p>ЧСС нь ажил мэргэжлийн үндэсний лавлахад тавигдсан шаардлагад нийцүүлэн боловсруулсан сургалтын хөтөлбөрөөр олгох мэргэшилтэй уялдсан байна. Ногоон хөгжлийн үзэл баримтлалд суурилсан тогтвортой хөгжлийн боловсролыг чадамжийн нэгж, элементүүд, сургалтын заах аргазүйд интеграцчилах замаар багш, суралцагчдад эзэмшүүлэх.</p>
5	<p>Салбарын хүний нөөцийн хөгжлийг тасралтгүй хангах, чадавхийг бэхжүүлэх – өөрийн эрхэлж буй ажлын чиг үүрэгтэй холбоотойгоор эзэмшиж буй мэдлэг, ур чадвараа нэмэгдүүлэх үйл ажиллагаа бөгөөд ихэвчлэн төлөвлөгөө, зорилготойгоор удирдлагын зөвшөөрлөөр хэрэгждэг. Хүний нөөцийн хөгжлийг тасралтгүй хангадаг олон хэлбэр байдаг бөгөөд хамгийн гол нь үйлдвэр, ажил олгогчдод нэвтрээд байгаа шилдэг, сайн туршлага, технологийн дэвшилтэй нийцэх явдал юм.</p>	<ul style="list-style-type: none"> • МБС-ын чанар болон нийцлийг сайжруулдаг. • Шинэчлэлийн бодлого, салбарын тогтолцоог боловсронгуй болгоход салбарын хүний нөөцийг татан оролцуулах замаар чадавхжуулах нь бодлого, шинэчлэлийн тогтвортой байдлыг хангах, эзний ёсоор хандах явдлыг дэмжих ач холбогдолтой. • ХЗЗ-ийн эрэлт, өөрчлөгдөж буй технологийн дэвшлийг багш нар суралцагчдад олгоно • Багш нарын зааж буй хичээл, жишээ баримт илүү бодитой болж өөртөө итгэх итгэл нэмэгдэнэ. • Багш нар бусад багү, ажилчиддаа мэдлэгээ түгээх, хуваалцана 	<p>МБС-ын багш, удирдах ажилтны стандарт, чадамжийн хүрээг тодорхойлон хүний нөөцийн хөгжил, бүтээмжийг үнэлдэг болох¹⁶ Олон хэлбэрт сургалтын хөтөлбөрийг нэвтрүүлэх, ялангуяа багшийн санал санаачлага бүхий төсөл, хөтөлбөрт дэмжлэг үзүүлэх. Салбарын болон сургуулийн түвшинд хүний нөөцийн удирдлага, сургалтын мэдээллийн систем бүрдүүлэх. Чадавх бэхжүүлэх үйл ажиллагаа нь жил бүр тасралтгүй, төсөвтэй байхаас гадна бодит амьдрал, хэрэгцээнд суурилсан байх. Удирдах ажилтны зүгээс мэргэжил дээшлүүлэх хэрэгцээг зөвхөн хүсэл сонирхол дээр үндэслэх биш хэрэгцээтэй мэдлэгийг эрэмбэлэн, үе шаттайгаар, тэгш шударга зарчмыг баримтлах.</p>
6	<p>МБС-ын санхүүжилтийн тогтолцооны сүүлийн үеийн чиг хандлага нь орцонд бус илүү сургалтын байгууллагын гүйцэтгэл, үр дүнд чиглэх төдийгүй хувьсан өөрчлөгдөж буй хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн уян хатан шинж чанартай байхаар тогтолцооны шинэчлэлийг хийж байна.</p>	<ul style="list-style-type: none"> • Үр дүн, гүйцэтгэлд суурилсан санхүүжилт нь МБС-ын чанар болон нийцлийг сайжруулдаг. • Санхүүжилтийг ХЗЗ болон орон нутгийн эрэлтэд нийцүүлэн бодитой санхүүжүүлэх боломжийг бүрдүүлнэ. • Санхүүжилтийн төлөвлөлт, зарцуулалт бодитой болж ирнэ. хандах явдлыг дэмжих ач холбогдолтой. 	<p>Өртөг, үр дүнд суурилсан МБС-ын санхүүжилтийн талаар олон улсын туршлагыг судлах, холбогдох тооцоо судалгаа хийх. Үүнтэй холбоотой санхүүжилтийн бүхий л эх үүсвэрийг нэгтэх, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих, тайлагнахтай холбоотой байгууллагын хариуцлагын болон нягтлан бодох бүртгэл мэдээллийн системийг сайжруулах. Санхүүгийн тооцоонд суурилсан шийдвэр гаргалтыг нэмэгдүүлэх, хүрээлэн буй орчинд ээлтэй, дэвшилтэт технологийг нэвтрүүлэхэд хөрөнгө оруулалтыг чиглүүлэх.</p>



2.4. ЗОРИЛТЫГ ХАНГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ

1. Нийгмийн түншлэл, хамтын ажиллагааг өргөжүүлэх, салбарын нэр хүндийг өсгөх хүрээнд:

- 1.1. МБС-ын Үндэсний зөвлөлийн үйл ажиллагааг бэхжүүлэх, салбар дундын зохицуулалтыг сайжруулах
- 1.2. Салбарын, орон нутгийн, сургалтын байгууллагын түвшин бүрт зөвлөлийн үйл ажиллагааг бэхжүүлэх
- 1.3. Элсэлт, сургалт, үнэлгээ, ажлын байртай холбох үйл ажиллагаанд ажил олгогч, мэргэжлийн холбоод, аж ахуйн нэгж, байгууллагуудын идэвхитэй оролцоог хангах
- 1.4. Төрийн бус болон хувийн хэвшлийн байгууллагуудаар салбарын зарим ажил үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлэх
- 1.5. Салбарын онцлог, нийгэмд гүйцэтгэх үүрэг, амжилт, бүтээлийн талаарх мэдээлэл, сурталчилгааны үйл ажиллагааг эрчимжүүлэх

2. Мэргэшлийн түвшний үндэсний тогтолцоог төлөвшүүлэх хүрээнд:

- 2.1. Мэргэшлийн түвшний үндэсний тогтолцоог бүрдүүлэх, түвшин бүрийн хүрээ, тодорхойлолтыг боловсруулж, мөрдөх
- 2.2. Албан бус боловсрол⁹, ажил амьдралын туршлагаас олж авсан мэдлэг, ур чадварыг хүлээн зөвшөөрөх тогтолцоо бүрдүүлэх
- 2.3. Төгсөгчдийн ур чадварын үнэлгээ, гэрчилгээжүүлэлтийг мэргэшлийн түвшний үндэсний тогтолцоотой уялдуулах
- 2.4. Тэргүүлэх салбарын ажил мэргэжлийн лавлах боловсруулж, баталгаажуулах
- 2.5. Мэргэшлийн түвшний үндэсний тогтолцооны талаар иргэд, олон нийт, ажил олгогчдын ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх

3. Чанарын баталгаажуулалт, байгууллагын менежмент, засаглалыг сайжруулах хүрээнд:

- 3.1. МБС-ын чанарын баталгаажуулалтын тогтолцоог бүрдүүлэх
- 3.2. Суралцагч, төгсөгчдийн мэргэжлийн ур чадварын үнэлгээний явцад хөндлөнгийн хяналт хийж баталгаажуулах
- 3.3. Сургалтын байгууллагын магадлан итгэмжлэл болон сургалтын хөтөлбөрийг баталгаажуулдаг чанарын хяналтын механизмыг хөгжүүлэх
- 3.4. Мэргэжлийн болон техникийн боловсрол сургалтын байгууллагад тавигдах шаардлагыг сургуулийн хэв шинжээс хамааруулан боловсронгуй болгох

⁹ Албан бус боловсрол” гэж боловсролын албан ёсны тогтолцооноос гадуур иргэнд боловсролын үйлчилгээ үзүүлэх зохион байгуулалттай үйл ажиллагааг хэлнэ, Боловсролын тухай хууль 3.1.7 заалт.



3.5. Үнэлгээ, мэдээллийн төв, Бүсийн арга зүйн төвийн арга зүйчдийг чадавхжуулах, үнэлгээний ажилтнууд болон салбарын шинжээч нарыг бэлтгэн, холбогдох байгууллагуудтай хамтран хөндлөнгийн үнэлгээг хийж, хэвшүүлэх

3.6. Салбарын түвшинд сургалт, удирдлагын нэгдсэн цахим мэдээллийн системийг хөгжүүлэх

3.7. Ногоон хөгжлийн үзэл санааг мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын менежмент болон сургалтын хөтөлбөрт тусгах;

3.8. Элсэлт, төгсөлтийн бодлого, төлөвлөлтийг хөгжлийн тэргүүлэх чиглэл, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, хэрэгцээтэй уялдуулах

3.9. Тэргүүлэх чиглэлийн үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын зонхилох мэргэжлээр МБС-ын байгууллагуудыг төрөлжүүлэх бодлого боловсруулах

4. Чадамжид суурилсан сургалт, үнэлгээний тогтолцоог төлөвшүүлэх хүрээнд:

4.1. Чадамжид суурилсан, сургалт үнэлгээний арга зүй, удирдамжийг боловсруулж, хэрэгжүүлэх

4.2. Ажил мэргэжлийн лавлахад үндэслэн мэргэжил бүрийн стандарт, ЧСС-ын хөтөлбөрүүдийг боловсруулах

4.3 Мэргэжлийн, техникийн болон дээд боловсролын агуулгын залгамж холбоог хангах

4.4. Цахим орчинд суурилсан чадамжийн санг бий болгож удирдах

4.5. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг мэргэжлийн боловсрол, сургалтад тэгш хамруулах боломжийг нэмэгдүүлэх

4.6. МБС-ын стандартад нийцүүлэн сургалтын орчинг сайжруулж шинэ, дэвшилтэт техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг нэвтрүүлэх

4.7. ЧСС-ын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах сурах бичиг, гарын авлага, материалыг мэргэжлийн багш, мэргэжлийн холбоод, ажил олгогчдын оролцоотойгоор боловсруулж, ашиглах

4.8. Сургалтад судалгаа-туршилт-үйлдвэрлэлийн нэгдлийг хангах, бизнес инкубатор төв байгуулах, үйл ажиллагааг нь тогтворжуулах

4.9. Иргэдэд ажиллангаа суралцах, суралцангаа хөдөлмөр эрхлэхэд чиглэсэн хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх

4.10. Суралцагч, олон нийтэд зориулсан ажил мэргэжлийн чиг баримжаа болон зөв хандлага, төлөвшлийг олгох үйл ажиллагааг хөгжүүлэх



5. Салбарын хүний нөөц, удирдлага, багшийн хөгжлийг тасралтгүй хангах, чадавхийг бэхжүүлэх хүрээнд:

- 5.1. Мэргэжлийн боловсрол, сургалтын багш, удирдах ажилтны мэргэшлийн ур чадварыг тодорхойлж, баталгаажуулах
- 5.2. “Мэргэжлийн боловсрол, сургалтын багшийн хөгжил” хөтөлбөр (2015-2020)-ийн хэрэгжилтийг хангах
- 5.3. “Мэргэжлийн боловсрол, сургалтын удирдах ажилтны хөгжил” хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх
- 5.4. Багшийн тасралтгүй хөгжих, мэргэшил дээшлүүлэх тогтолцоог бий болгох
- 5.5. Багш нарыг үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагын дэвшилтэт тоног төхөөрөмж дээр дадлагажуулах, багш-инженер техникийн ажилтнуудын солилцооны хөтөлбөрийг хэрэгжүүлэх
- 5.6. Салбарын хүний нөөцийн хангамжийг сайжруулж, цалин, урамшуулал, нийгмийн хамгааллыг дээшлүүлэх
- 5.7. Суралцагчид, багш нарын мэдлэг, авъяас, ур чадварыг нээн хөгжүүлэх, үндэсний болон олон улсын хэмжээний тэмцээн, уралдаанд оролцуулах, амжилт гаргасан багш, суралцагчдад урамшуулал, дэмжлэг олгох механизмыг бүрдүүлэх
- 5.8. МБС-ын байгууллагууд болон багш нарын дунд инноваци, эрдэм шинжилгээ, судалгааны үйл ажиллагааг идэвхижүүлж, чадавхи бэхжүүлэх
- 5.9. Судлаачид, багш нар, суралцагчдын инноваци, бүтээлийг оюуны өмчөөр хамгаалж, бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийг бий болгох зорилгоор технологийн төсөл хэрэгжүүлэн эдийн засгийн эргэлтэд оруулах

6. Санхүүжилтийн тогтолцоог боловсронгуй болгох хүрээнд:

- 6.1. Салбарт хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрүүдийн нэгдмэл байдлыг хангаж, үр өгөөжийг дээшлүүлэх
- 6.2. МБС-ын байгууллагуудын санхүүжилтийг мэргэжлийн өөрийн өртөгт суурилан олгох механизмыг бүрдүүлэх
- 6.3. МБС-ын байгууллагуудын өөрийн үйл ажиллагаанаас орлого олох, зарцуулах, тайлагнах арга хэмжээг хэрэгжүүлэх
- 6.4. МБС-ын дэмжих сангийн үйл ажиллагааг хангах



ГУРАВ. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, САНХҮҮЖИЛТ

Үндэсний хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд чиглэсэн зорилт нэг бүрийг хэрэгжүүлэх бүтэц, зохион байгуулалт байх бөгөөд аль болох улсын төсөвт хүндрэл бага учруулахаар олон талын санхүүжилтийн эх үүсвэрээр тус хөтөлбөрийг санхүүжүүлэхээр боловсрууллаа.

3.1. ХУГАЦАА, ҮЕ ШАТ

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа 2016-2021 он байх бөгөөд дараах үндсэн дөрвөн үе шаттай арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

- Бэлтгэл үе: 2016 он хөтөлбөрийг хэрэгжүүлэх бэлтгэл хангах үе бөгөөд суурь судалгаа хийх, хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотой нарийвчилсан төлөвлөгөө гаргах, талуудад мэдээлэх, тэдний оролцоо, чиг үүргийг тодорхойлох, зарим бодлогын баримт бичгүүдийн анхны төсөл боловсруулагдана.
- Хэрэгжилтийн үе шат: 2017-2019 он хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбогдсон дүрэм, журам, баримт бичгийг боловсруулан баталгаажуулах, хүний нөөцийг чадавхижуулах, туршин нэвтрүүлэх, хэрэгжилтийг зохион байгуулах үе шат байна.
- Явцын үнэлгээ хийх үе шат: 2019 он хөтөлбөрийн хэрэгжилтийн дунд хугацаанд зорилтот түвшинд хүрсэн эсэхэд үнэлгээ хийж, дүгнэлт, зөвлөмж гаргана. Энэ шатанд төлөвлөгөөт ажлын гүйцэтгэл болон туршин нэвтрүүлж буй ажлаа дүгнэн, баталгаажуулах цаашид үндэсний хэмжээнд түгээн дэлгэрүүлэх эсэхийг шийдвэрлэх, 2019-2021 онд хэрэгжүүлэх ажлыг эрэмбэлэх, нөөцийн дахин хувиарлалт хийх шаардлагатай нэмэлт, өөрчлөлт оруулах, засч сайжруулах ажил хийгдэнэ.
- Хөтөлбөрийг нэгтгэн дүгнэх, тайлагнах үе шат: 2021 он хөтөлбөрийн биелэлтийг дүгнэх буюу зорилт бүрээр шалгуур үзүүлэлтүүдийг хангасан эсэхийг үнэлэх, оролцогч талууд хийсэн ажлаа тайлагнах, хэлэлцүүлэг зохион байгуулах, цаашдын бодлого, төлөвлөлтийг боловсруулах чиглэлээр санал зөвлөмж гаргана.


Хөтөлбөрийн зорилт бүрийн биелэлтийг хангах үйл ажиллагааг мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцах бөгөөд хамтран ажиллах байгууллагуудын жилийн болон урт хугацааны хөтөлбөр, төлөвлөгөөнд тусгах замаар зохион байгуулна.



3.2. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Үндэсний хөтөлбөрийг мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцан хэрэгжүүлэх бөгөөд талуудын оролцоог хангаж ажиллана (Зураг 10).

Зураг 10. Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалт



Хөтөлбөрийг хэрэгжүүлэх оролцогч талуудын чиг үүрэг.

- МБСҮЗ: Мэргэжлийн боловсрол, сургалтын дээд удирдлагыг хэрэгжүүлэгч МБСҮЗ нь хуулиар тогтоосон бүрэн эрхийнхээ хүрээнд Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зорилгоор бодлого төлөвлөлт болон тайланг хэлэлцэн дүгнэлт гаргах, тогтоол, зөвлөмж гаргах, чиглэл өгөх, гаргасан шийдвэр, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавих,
- Хөдөлмөрийн яам: Хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган, мэргэжил арга зүйн удирдлагаар оролцогч талуудыг хангаж, ажиллана.
- Хөтөлбөрийн зохицуулагч: Зохицуулагч нь МБС-ын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын газрын дарга байх бөгөөд хөтөлбөрийн зорилт нэг бүрээр хэрэгжилтийг хангаж ажиллана. Хөтөлбөрийн зорилтот тусгасан үйл ажиллагаа бүрийг байгууллагын жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлнэ.
- Мэргэжилтнүүд: Үндэсний хөтөлбөрийн зорилт бүрийг МБС-ын байгууллагын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын холбогдох мэргэжилтнүүд хариуцах ба мэргэжилтнүүдийн жил бүрийн үр дүнгийн гэрээнд тусгах замаар хэрэгжүүлнэ. Тухайн зорилтот үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ оролцогч талуудтай хамтран ажиллах бөгөөд шаардлагатай тохиолдолд ажлын хэсэг байгуулан ажиллаж болно.



3.3. САНХҮҮЖИЛТИЙН ЭХ ҮҮСВЭР

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хүний нөөцийн болон санхүүгийн оновчтой төлөвлөлт, хувиарлалт хийж ажиллах бөгөөд санхүүжилт нь дараах эх үүсвэрүүдээс бүрдэнэ. Үүнд:

- Улсын болон орон нутгийн төсөв
- Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан
- Олон улсын байгууллагууд, гадаадын зээл, хандив, тусламж
- Салбарт хэрэгжүүлэх дотоод, гадаадын төсөл, хөтөлбөрийн санхүүжилт
- Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт
- Бусад эх үүсвэр

Хөтөлбөрт тусгагдсан үндсэн зургаан зорилт, тэдгээрийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны үе шат, шаардлагатай төсөв, хамтран ажиллах байгууллагын мэдээллийг хөтөлбөрийг хэрэгжүүлэх жил бүрийн төлөвлөгөөнөөс харна уу.



ДӨРӨВ. БОДЛОГЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Хөгжлийн бодлогын баримт бичигт дэвшүүлсэн зургаан зорилт, холбогдох үйл ажиллагаа бүрийг хэрэгжүүлснээр гарах ахиц дэвшлийг үнэлэх шалгуур үзүүлэлт, түүнийг хэмжих нэгж, хүрэх түвшин, үр дүнг судалгаа тооцоонд үндэслэн тодорхойлсон ба мөн шалгуур үзүүлэлтийн нотолгоог цуглуулах мэдээллийн эх сурвалж, байгууллагыг тодорхойлсон болно.

4.1. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ХҮРЭХ ҮР ДҮН

Тухайн зорилтот үйл ажиллагааг хэрэгжүүлэх шалгуур үзүүлэлт, суурь үзүүлэлт, хүрэх үр дүнг төрийн захиргааны төв байгууллагын мэдээлэл, статистик тоо баримт, төрөөс боловсролын талаар баримтлах бодлого, Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал-2030 зэрэг томоохон баримт бичгүүдэд туссан зорилго, зорилт, шалгуур үзүүлэлттэй нийцүүлсэн болно.

Үндэсний хөтөлбөрийн суурь он нь 2016 он байх бөгөөд хүрэх үр дүн, үр нөлөөг Засгийн газрын 2013 оны 322 дугаар тогтоолоор баталсан “Захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ үнэлгээний нийтлэг журам”-д заасны дагуу хэмжигдэхүйц тоон үзүүлэлтээр илэрхийлсэн. Тоогоор илэрхийлэгдэх боломжгүй чанарын үзүүлэлтийг тодорхой тогтоосон бөгөөд зарим шалгуур үзүүлэлтийн биелэлтийг хувиар илэрхийлэв.

4.2. ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН НОТОЛГОО, МЭДЭЭЛЛИЙН ЭХ СУРВАЛЖ

Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийн нотолгооны үндсэн мэдээллийн эх сурвалж нь хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, түүний харъяа байгууллагуудын мэдээлэл, статистик тоо баримт байна. Зарим нотолгоо нь тусгайлсан судалгаа явуулах болон шинээр статистик баримт боловсруулж цуглуулж авах мэдээлэл байна.



ТАВ. ХЭРЭГЖИЛТИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийг 2016-2021 онд холбогдох бусад төсөл хөтөлбөртэй уялдуулан зохион байгуулах бөгөөд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх, тайлагнах арга хэмжээг мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага зохион байгуулна.

- Тухайн жилд төлөвлөсөн үйл ажиллагааны хэрэгжилтэд жил бүр үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайлагнана.
- Үр дүнд суурилсан явцын үнэлгээг 2019 оны эхний улиралд багтааж, хөтөлбөрийн хэрэгжилтийн дунд хугацаанд зорилтот түвшинд хүрсэн эсэхэд үнэлгээ хийж дүгнэлт, зөвлөмж гаргана.
- Үр дүнд суурилсан нэгтгэн дүгнэх үнэлгээг 2021 оны эхний хагас жилд багтааж, үндэсний хөтөлбөрийн биелэлт зорилтот түвшинд хүрсэн эсэхэд эцсийн байдлаар үнэлж, үр дүн, үр нөлөөг тодорхойлон, цаашдын бодлого боловсруулах чиглэлээр дүгнэлт, зөвлөмж гаргана.

Үр дүнд суурилсан явцын болон нэгтгэн дүгнэх үнэлгээг зохион байгуулахдаа Мэргэжлийн боловсрол, сургалтын Үндэсний зөвлөл, ажил олгогч, бусад түншүүдийн төлөөллийн оролцоог хангаж ажиллана. Шаардлагатай бол хөндлөнгийн байгууллагаар гүйцэтгүүлж болно.

Хөтөлбөрийн хэрэгжилт, түүний мөрөөр авсан арга хэмжээ олон нийтэд ил тод, нээлттэй байх бөгөөд мэдээллийг төрийн захиргааны төв байгууллагын цахим хуудас (www.mol.gov.mn) дээр тогтмол байршуулна.



НОМ ЗҮЙ

Хууль эрх зүй, үндэсний хөтөлбөрүүд

1. Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль
2. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль
3. Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030
4. Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал
5. Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр (2012-2016)
6. “Ажилтай, орлоготой монгол хүн” Үндэсний хөтөлбөр
7. Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого (2014-2024)
8. Боловсрол Үндэсний хөтөлбөр (2010-2021 он)

АШИГЛАСАН НОМ

1. Ж.Юра, С.Лувсанвандан, Эрдэм шинжилгээний бичиг, Мэргэжлийн боловсрол, сургалтын тогтолцооны үүсэл, хөгжил, шинэчлэл, Олон улсын эрдэм шинжилгээний бага хурал, Улаанбаатар хот 2014 он
2. Хөдөлмөрийн яамны Мэргэжлийн боловсрол, сургалтын бодлого зохицуулалтын газар, Мэргэжлийн боловсрол, сургалтын статистик мэдээлэл, 2015-2016 оны хичээлийн 1 хагас жил, 2016 он
3. Д.Алтангэрэл, Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа-2015, 2012-2013 оны хичээлийн жилд төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн мөшгөх судалгаа, 2015 он
4. Г.Мягмардулам, М.Уянга, Барометрийн судалгаа, 2015 он
5. Д.Сайхан-Ой, Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа, 2010-2011 оны хичээлийн жилд төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийг мөшгөх судалгаа, 2015 он
6. Монголын мянганы сорилтын сан, Мянганы сорилтын сангийн мэргэжлийн боловсрол, сургалтын төслийн хүрээнд хийгдсэн хөдөлмөрийн зах зээлийн судалгаа, 2010 он
7. Мэргэжлийн боловсрол, сургалтын газар, Мэргэжлийн боловсрол, сургалт, зорилт, үйл ажиллагаа, үр дүн, 2012 он
8. Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, судалгаа, мэдээллийн үндэсний төв, МСҮТ төгсөгчдийн мэдээллийг цуглуулах, нэгтгэх үйл явцын шинжилгээ, 2015 он
9. Хөдөлмөрийн яам, Чадамжид суурилсан сургалтын үнэлгээний гарын авлага, 2014 он
10. Мэргэжлийн боловсрол, сургалтын газар, Мэргэжлийн боловсрол, сургалтын газрын 2011 оны үйл ажиллагааны тайлан, 2011 он
11. Хөдөлмөрийн яам, Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын чанарын баталгааны хүрээ, тогтолцоо /гарын авлага/, 2014 он
12. Хөдөлмөрийн яам, Хууль зүйн үндэсний хүрээлэн, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, санхүүгийн ажилтанд зориулсан эрх зүйн баримт бичгийн эмхэтгэл, 2015 он
13. Хөдөлмөрийн яам, Хөдөлмөрийн зах зээлийн үндсэн үзүүлэлт, Хөдөлмөрийн салбарын ажилтнуудын ажлын хэрэгцээнд зориулсан



- гарын авлага /Монгол, Англи хэл дээр/, 2015 он
14. Хөдөлмөрийн яам, Дунд ба урт хугацааны хөдөлмөрийн эрэлт, нийлүүлэлтийн таамаглал 2015
 15. Хөдөлмөрийн яам, Монголын эдийн засгийн олон секторт загвар, 2015 он
 16. UNESCO UNEVOC, UNESCO TVET Strategy 2016-2021: Report of the UNESCO-UNEVOC virtual conference, 28 September to 03 October, 2015.
 17. UNESCO, Shanghai consensus, Third International Congress on TVET: Transforming TVET – Building skills for work and life.
 18. UNESCO, Unleashing the potential: Transforming TVET
 19. SOLAS Further education and training authority, Further Education and Training Strategy 2014–2019
 20. Saha Meyanathan, STVET-1 project, Current financing system of TVET sector in Mongolia and alternative financing mechanisms in cross country examples, 2016

ИНТЕРНЭТИЙН ЭХ ҮҮСВЭР

1. Хөдөлмөрийн яам: <http://www.mol.gov.mn/>
2. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем: www.legalinfo.mn
3. Нэгдсэн үндэсний байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагын Техникийн ба мэргэжлийн боловсрол, сургалтын олон улсын төв: <http://www.unevoc.unesco.org/>
4. Статистикийн мэдээллийн нэгдсэн сан: www.1212.mn
5. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын сургалтудирдлагын нэгдсэн систем: e-tvet.mnовсрол, сургалтын багшийн хөгжил' хөтөлбөр, 2015 он
6. МБС-ын хүний нөөцийн чадамжийн хүрээ (Competence frameworks for TVET professionals) нь багш, сургагч болон удирдлагуудад шаардлагатай ур чадвар, мэдлэг, чадамжуудын тодорхойлолт юм. Энэхүү чадамжийн хүрээг боловсруулснаар багшийн хөгжлийн талаар бодлого боловсруулах, арга хэмжээ авахад төр засгийн байгууллагад ач холбогдол өгөхөөс гадна тухайн багш, ажилтнуудын хувьд хийж буй ажилдаа анхаарах, өөртөө илтгэлтэй байх, өсч хөгжих нөхцлийг бүрдүүлдэг. Ингэхдээ, тухайн мэргэжлийн салбарт багшийн чадамж, аргазүйг үнэлж, гэрчилгээжүүлэх эрх бүхий салбарын мэргэшсэн үнэлээч нарыг бэлтгэх замаар хэрэгжүүлнэ (UNEVOC, Transforming TVET page 113).



ХАВСРАЛТ 1. ЧСС-ЫН ХӨТӨЛБӨР БОЛОН АЖИЛ МЭРГЭЖЛИЙН ЛАВЛАХ

1. ЧСС-ЫН ХӨТӨЛБӨРИЙН ЖАГСААЛТ

Дараах хөтөлбөрүүд нь салбарын хэмжээнд туршигдаж, боловсруулагдсан болно.

№	Салбар	ЧСС-ын хөтөлбөрийн нэр	МС	МБ	ТБ
1	Аж үйлдвэр	Оёдол			
2		Токарь фрезерчин			
3		Цахим тоног төхөөрмжийн үйлчилгээний ажилтан			
4		Аж үйлдвэрийн байгууламжийн технологийн техникч			
5		Үйлдвэрийн цахилгаанч			
6		Баяжуулалтын операторчин			
7	Уул уурхай	Оператор, газрын тос олборлох давхаргын даралт тогтворжуулах ажилтан			
8		Баяжуулах үйлдвэрийн тоног төхөөрөмжийн засварчин			
9		Уурхайн цахилгаанчин			
10		Уул уурхайн нөхөн сэргээгч			
11		ХММ-ын засварчин			
12		Өрмийн мастер			
13	Мэдээл-лийн технологи	Нарийн бичгийн дарга, албан хэргийн ажилтан			
14		Компьютер үйлчилгээний ажилтан			
15		Мэдээллийн технологич			
16	Барилга	Бетон арматорчин			
17		Угсрагч системийн салхивч агааржуулалтын Т/Т-ийн ажилтан			
18		Барилгын цахилгаанчин			
19		Гагнуурчин			
20		Барилгын мужаан			
21		Барилгын засал			
22		Барилгын өрөг угсрагч			
23		Барилгын сантехник			
24	Зам тээвэр	Авто зам гүүр, барилгын ажилтан			
25		Мэргэшсэн жолооч			
26		Хүнд машин механизмын операторчин			
27		Илчит тэрэгний туслах машинч			
28		Автомашин засварчин			



29	ХАА	ХАА-н машин механизмын операторчин			
30	Эрчим хүч	Зуухны машинч			
31		Өндөр хүчдэлийн монтёр			
32	Байгаль орчин, аялал жуулчлал	Зочид буудал зоогийн газрын үйлчилгээний ажилтан			
33	Хүнсний үйлдвэрлэл	Тогооч			
34	Соёл урлаг	Хувцас загвар зохион бүтээгч			
35		Интерьер дизайнч			

2. АЖИЛ МЭРГЭЖЛИЙН ЛАВЛАХУУД

№	Ажил мэргэжлийн лавлах
1	Мах махан бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрлэлийн ажилтан
2	Туслах сувилагч
3	Хэвлэлийн график дизайн
4	Зүтгүүрийн машинч
5	Зочид буудлын өрөөний үйлчлэгч
6	Сүлжих машины операторч
7	Тогооч
8	Гагнуурчин
9	Шилэн фасад угсрагч
10	Үслэг эдлэлийн оёдолчин
11	Хуурай хийц угсрагч
12	Оёдолчин
13	Асфальт бетон хольц ба битумын лабораторийн лаборант
14	Асфальт бетон хучлагад нүхэн засвар хийх иж бүрдэл машины операторч
15	Гуталчин /зариалгын/
16	Барилгын шат угсрагч
17	ХАА-н машин, тоног төхөөрөмжийн механикч
18	Барилгын дээвэрчин
19	Үйлдвэрлэлийн машин, тоног төхөөрөмжийн механикч
20	Токарьч-фрезерч

АЛБАН ЁСООР БАТАЛГААЖСАН
МЭРГЭЖЛИЙН БОЛОН
ТЕХНИКИЙН БОЛОВСРОЛЫГ
ХӨГЖҮҮЛЭХ ҮНДЭСНИЙ
ХӨТӨЛБӨР /**2016-2021**/





МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2016 оны 6 дугаар
сарын 6-ны өдөр

Дугаар 304

Улаанбаатар хот

ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР БАТЛАХ ТУХАЙ

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 10.3, 10.5, 10.6-д заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Мэргэжлийн болон техникийн боловсролыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг хавсралт ёсоор баталсугай.

2. Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталж, биелэлтэд нь хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөрийн сайд Г.Баярсайханд үүрэг болгосугай.

3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг жил бүрийн улсын төсөв болон улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгаж, гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламж, төсөл, хөтөлбөрт хамруулах замаар санхүүжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Хөдөлмөрийн сайд Г.Баярсайхан, Сангийн сайд Б.Болор нарт даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайд
Хөдөлмөрийн сайд

Ч.САЙХАНБИЛЭГ
Г.БАЯРСАЙХАН

Засгийн газрын 2016 оны 304 дүгээр
тогтоолын хавсралт

МЭРГЭЖЛИЙН БОЛОН ТЕХНИКИЙН БОЛОВСРОЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР



Нэг. Нийтлэг үндэслэл

“Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 196.1-д “Мэргэжлийн боловсрол, сургалтыг хөгжүүлэх мастер төлөвлөгөө”-г батлан хэрэгжүүлэхээр заасан бөгөөд цаашид Мэргэжлийн боловсрол, сургалтыг хөгжүүлэх арга хэмжээг төр, хувийн хэвшил, олон улсын байгууллагуудын хамтын ажиллагаанд тулгуурлан бүс нутгийн хөгжил, байгаль орчны тогтвортой байдлыг хангахад чиглүүлж шинэчлэх шаардлагатай байна.

Мэргэжлийн болон техникийн боловсролыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр (цаашид “хөтөлбөр” гэх)-ийг Монгол Улсын Үндсэн хууль, Мэргэжлийн боловсрол сургалтын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Боловсролын тухай хууль, Төсвийн тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулсан бөгөөд энэхүү хөтөлбөр нь Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” болон 2015 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого”-д дэвшүүлсэн зорилго, зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний бүрэлдэхүүн хэсэг болно.

Энэхүү хөтөлбөрт мэргэжлийн боловсрол, сургалтын салбарын шинэчлэлийг хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцүүлэх, төр, хувийн хэвшлийн түншлэлийн бодит механизм бүрдүүлж төлөвшүүлэх, үйлдвэрлэлийн хөгжлийн хэрэгцээтэй холбож төрөлжүүлэх, мэргэжлийн боловсрол, сургалтын стандарт, хөтөлбөрийг шинэчлэх, багш нарыг заах арга зүй болон мэргэшсэн инженер техникийн ажилтны түвшинд чадваржуулах, үйлдвэрлэл-дадлагын сургалтын бааз, лабораторийг орчин үеийн шаардлагад нийцүүлэх, сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүнээр хангах, иргэдийн хэрэгцээнд суурилсан үйлчилгээг нэвтрүүлэх, эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх асуудлыг тусгана.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго, зорилт

2.1. Хөтөлбөрийн зорилго

Монгол Улсын хөгжлийн бодлого, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, шаардлагад нийцсэн, иргэдийн хэрэгцээ, авъяас, сонирхолд тохирсон мэргэжлийн болон техникийн боловсролыг шинэчлэн хөгжүүлж, чанар, хүртээмж, үр өгөөжийг дээшлүүлэхэд хөтөлбөрийн зорилго оршино.

2.2. Хөтөлбөрийн зорилт

Хөтөлбөрийн зорилгын хүрээнд дараах зорилтуудыг хэрэгжүүлнэ:

2.2.1. нийгмийн түншлэл, хамтын ажиллагааг өргөжүүлэх:

2.2.2. мэргэшлийн түвшний үндэсний тогтолцоог төлөвшүүлэх:

2.2.3. мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын



байгууллагын менежмент, сургалтын стандартыг сайжруулах:

2.2.4. ажил, мэргэжлийн чадамжид суурилсан сургалт, үнэлгээний тогтолцоог төлөвшүүлэх:

2.2.5. мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын хүний нөөцийн хөгжлийг дэмжих арга хэмжээг авч, чадавхийг бэхжүүлэх:

2.2.6. мэргэжлийн болон техникийн боловсролын санхүүжилтийн тогтолцоог боловсронгуй болгох.

Гурав.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үе шат

3.1. Хөтөлбөрийг 2016-2021 онд дараах үе шаттай хэрэгжүүлнэ:

3.1.1.хөтөлбөрийг хэрэгжүүлэх бэлтгэл, суурь судалгааны үе шат 2016 он;

3.1.2. хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай дүрэм, журам, холбогдох бусад баримт бичгийг боловсруулан батлах, хүний нөөцийг чадавхжуулах, хэрэгжилтийг зохион байгуулах үе шат 2017-2019 он;

3.1.3. хөтөлбөрийн биелэлтийг хангах, зорилтот түвшинд хүрсэн эсэхэд дүгнэлт, зөвлөмж өгөх үе шат 2019-2021;

Дөрөв. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа

4.1. Нийгмийн түншлэл, хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилтын хүрээнд:

4.1.1. мэргэжлийн боловсрол, сургалтын Үндэсний зөвлөлийн үйл ажиллагааг бэхжүүлэх, салбар дундын зохицуулалтыг сайжруулах;

4.1.2. мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын үйл ажиллагаанд ажил олгогч, мэргэжлийн холбоод, аж ахуйн нэгж, байгууллагуудын идэвхтэй оролцоог хангах;

4.1.3. мэргэжлийн боловсрол, сургалттай холбоотой зарим чиг үүргийг төрийн болон хувийн хэвшлийн байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлэх;

4.1.4. мэргэжлийн болон техникийн боловсролын онцлог, нийгэмд гүйцэтгэх үүрэг, амжилт, бүтээлийн талаарх мэдээлэл, сурталчилгааны үйл ажиллагааг эрчимжүүлэх;

4.2. Мэргэшлийн түвшний үндэсний тогтолцоог төлөвшүүлэх зорилтын хүрээнд:

4.2.1. мэргэшлийн түвшний үндэсний тогтолцоог бүрдүүлэх, мэргэжлийн түвшин бүрийн хүрээ, тодорхойлолтыг боловсруулж мөрдөх;

4.2.2. албан бус боловсрол, ажил, амьдралын туршлагаас олж авсан мэдлэг, ур чадварыг хүлээн зөвшөөрөх тогтолцоог бүрдүүлэх;

4.2.3. төгсөгчдийн ур чадварын үнэлгээнд үндэслэн мэргэжлийн үнэмлэх, гэрчилгээ олгох үйл ажиллагааг мэргэшлийн түвшний үндэсний тогтолцоотой уялдуулах;

4.2.4. улс тэргүүлэх салбарын ажил, мэргэжлийн жагсаалт гаргах;

4.2.5. мэргэшлийн түвшний үндэсний тогтолцооны талаар иргэд, олон нийт, ажил олгогчдын ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх.

4.3. Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын



менежмент, сургалтын стандартыг сайжруулах зорилтын хүрээнд:

- 4.3.1. мэргэжлийн боловсрол, сургалтын чанарын баталгаажуулалтын тогтолцоог бүрдүүлэх;
- 4.3.2. суралцагч, төгсөгчдийн мэргэжлийн ур чадварын үнэлгээнд хөндлөнгийн хяналт хийх баталгаажуулах;
- 4.3.3. мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын байгууллагын магадлан итгэмжлэл болон сургалтын хөтөлбөрийг баталгаажуулдаг чанарын хяналтын механизмыг хөгжүүлэх;
- 4.3.4. мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын байгууллагад тавих шаардлагыг боловсронгуй болгох;
- 4.3.5. мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ, мэдээллийн төв, бүсийн арга зүйн төвийн арга зүйчийг чадавхжуулах, үнэлгээний ажилтан, салбарын шинжээч бэлтгэж, холбогдох байгууллагуудтай хамтран хөндлөнгийн үнэлгээг хийж хэвшүүлэх;
- 4.3.6. салбарын түвшинд сургалт, удирдлагын нэгдсэн цахим мэдээллийн системийг хөгжүүлэх;
- 4.3.7. мэргэжлийн болон техникийн боловсролын бодлого, төлөвлөлтийг хөгжлийн тэргүүлэх чиглэл, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, хэрэгцээтэй уялдуулах;
- 4.3.8. мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагыг тэргүүлэх салбарын ажил, мэргэжлийн чиглэлээр төрөлжүүлэх бодлого боловсруулах;

4.4. Ажил, мэргэжлийн чадамжид суурилсан сургалт, үнэлгээний тогтолцоог төлөвшүүлэх зорилтын хүрээнд:

- 4.4.1. ажил, мэргэжлийн чадамжид суурилсан сургалт, үнэлгээний арга зүй, удирдамжийг боловсруулж хэрэгжүүлэх;
- 4.4.2. ажил, мэргэжлийн үндэсний ангилалд үндэслэн мэргэжил бүрийн стандарт, чадамжид суурилсан сургалтын хөтөлбөрийг боловсруулах;
- 4.4.3. мэргэжлийн боловсрол, сургалтын агуулгад дээд боловсролын сургалтын агуулгын залгамж холбоог хангах;
- 4.4.4. хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг мэргэжлийн боловсрол, сургалтад тэгш хамруулах боломжийг нэмэгдүүлэх;
- 4.4.5. мэргэжлийн боловсрол, сургалтын стандартад нийцүүлэн сургалтын орчныг сайжруулж, шинэ, дэвшилтэт техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлээр хангах;
- 4.4.6. сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах сурах бичиг, гарын авлага, материалыг мэргэжлийн багш, мэргэжлийн холбоод, ажил олгогчдын оролцоотойгоор боловсруулж ашиглах;
- 4.4.7. мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын дэргэд бизнес инкубатор төв байгуулан, уг төвийн үйл ажиллагааг тогтмолжуулах;
- 4.4.8. суралцагчид, төгсөгчдөд ажил, мэргэжлийн чиг баримжаа, зөв хандлага, төлөвшлийг олгох үйл ажиллагааг хөгжүүлэх.

4.5. Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын хүний нөөцийн хөгжлийг дэмжих арга хэмжээ авч, чадавхийг бэхжүүлэх зорилтын хүрээнд:

- 4.5.1. мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын багш, удирдах



ажилтны мэргэшлийн ур чадварыг тодохойлж, цаашид хөгжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх;

4.5.2. “Мэргэжлийн боловсрол, сургалтын багшийн хөгжил” хөтөлбөр (2015-2020)-ийн хэрэгжилтийг хангах;

4.5.3. “Мэргэжлийн боловсрол, сургалтын удирдах ажилтны хөгжил” хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх;

4.5.4. багшийн тасралтгүй хөгжих, мэргэшил дээшлүүлэх тогтолцоог бий болгох;

4.5.5. багш нарыг үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагын дэвшилтэт тоног төхөөрөмж дээр дадлагажуулах, багш-инженер, техникийн ажилтнуудын солилцооны хөтөлбөр хэрэгжүүлэх;

4.5.6. мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын багшийг бэлтгэх, цалин, урамшуулал, нийгмийн хамгааллыг сайжруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

4.5.7. багш, суралцагчдын мэдлэг, авьяас, ур чадварын нээн хөгжүүлэх, үндэсний болон олон улсын хэмжээний тэмцээн, уралдаанд оролцуулах, амжилт гаргасан багш, суралцагчдад урамшуулал олгох, дэмжлэг үзүүлэх механизмыг бүрдүүлэх;

4.5.8. мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагууд болон багш нарын дунд инноваци, эрдэм шинжилгээ, судалгааны үйл ажиллагааг идэвхжүүлж, чадавхийг бэхжүүлэх;

4.5.9. судлаачид, багш нар, суралцагчдын инноваци, бүтээлийг оюуны өмчөөр хамгаалж, бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийг бий болгох зорилгоор технологийн төсөл хэрэгжүүлэн эдийн засгийн эргэлтэд оруулах.

4.6. Мэргэжлийн болон техникийн боловсролын санхүүжилтийн тогтолцоог боловсронгуй болгох зорилтын хүрээнд:

4.6.1. мэргэжлийн боловсролын салбарт хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрүүдийн нэгдмэл байдлыг хангаж, үр өгөөжийг дээшлүүлэх;

4.6.2. мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагуудын санхүүжилтийг өөрийн өртөгт суурилан олгох механизмыг бүрдүүлэх;

4.6.3. мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагууд өөрийн үйл ажиллагаанаас орлого олох, зарцуулах, тайлагнах нөхцөлийг бүрдүүлж, хэрэгжүүлэх;

4.6.4. мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн үйл ажиллагааг боловсронгуй болгох.

Тав. Хөтөлбөрийн үр дүн, шалгуур үзүүлэлт

5.1. Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараах үр дүн гарна:

5.1.1. Мэргэжлийн боловсрол, сургалтын Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүн, дүрэм шинэчлэгдэж, үйл ажиллагаа нь бэхжин мэргэжлийн боловсрол, сургалтыг байгууллагын үйл ажиллагаанд бусад оролцогчдын оролцоо нэмэгдсэн байна;

5.1.2. шинээр үйлдвэр, үйлчилгээний 4 салбар зөвлөл байгуулагдан үйл ажиллагаа нь тогтмолжсон байна;

5.1.3. мэргэшлийн түвшний үндэсний тогтолцоо бүрдсэн байна;

5.1.4. үнэлгээ, мэдээллийн төвөөр дамжуулан албан бус болон



- ажил, амьдралын туршлагаас олж авсан мэдлэг, ур чадвараа 100-аас доошгүй иргэн үнэлүүлж, гэрчилгээ авсан байна;
- 5.1.5. мэргэжлийн үнэмлэх, гэрчилгээ авсан төгсөгчдийн мэдээллийн сан бүрдсэн байна;
- 5.1.6. тэргүүлэх салбарын ажил, мэргэжлийн жагсаалт батлагдсан байна;
- 5.1.7. мэргэжлийн боловсрол, сургалтын чанарын баталгаажилтын хамрах хүрээ тодорхойлогдсон байна;
- 5.1.8. мэргэжлийн боловсрол, сургалтын 20-иос доошгүй байгууллага, 15-аас доошгүй чадамжид суурилсан сургалтын хөтөлбөр магадлан итгэмжлэгдсэн байна;
- 5.1.9. үндэсний хэмжээнд 45-аас доошгүй үнэлгээний ажилтан бэлтгэгдсэн байна;
- 5.1.10. сургалт, удирдлагын цахим мэдээллийн нэгдсэн систем бий болж, үйл ажиллагаа нь жигдэрсэн байна;
- 5.1.11. мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин 70 хувьд хүрсэн байна;
- 5.1.12. мэргэжлийн боловсрол, сургалтын агуулгыг дээд боловсролын сургалтын агуулгатай дүйцүүлсэн 20 сургалтын хөтөлбөр боловсруулсан байна;
- 5.1.13. хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан 5 мэргэжлийн ангийг шинээр нээж, үйл ажиллагааг хангасан байна;
- 5.1.14. мэргэжлийн боловсрол, сургалтын стандартад нийцүүлэн 26 мэргэжлийн чиглэлээр шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгсэлийг шинэчилсэн байна;
- 5.1.15. мэргэжлийн сурах бичиг, гарын авлага, материал 20 төрлийг боловсруулж, түгээсэн байна;
- 5.1.16. бүс бүрт мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын дэргэд туршилт-үйлдвэрлэлийн бизнес инкубаор төв байгуулж, 90-ээс доошгүй аж ахуйн нэгж бойжуулсан байна;
- 5.1.17. ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөх үйлчилгээ болон хөдөлмөрийн зөв хандлага, төлөвшлийг суралцагч, олон нийтэд олгох үйл ажиллагааг мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагуудад нэвтрүүлсэн байна;
- 5.1.18. мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтыг эрэлтэд нийцүүлэн суралцагчдын тоог 60 мянгад хүргэсэн байна;
- 5.1.19. мэргэжлийн боловсрол, сургалтын багш, удирдах ажилтны мэргэшлийн ур чадварыг тодорхойлж, баталгаажуулсан байна;
- 5.1.20. “Мэргэжлийн боловсрол, сургалтын багшийн хөгжил” хөтөлбөрийн биелэлт 90-ээс дээш хувьд хүрсэн байна;
- 5.1.21. мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын мэргэжлийн багш нарын 40-өөс багагүй хувь аж ахуйн нэгж, байгууллагад дадлага хийж, ур чадвараа дээшлүүлсэн байна;
- 5.1.22. дэлхийн ур чадварын тэмцээнд 2 удаа оролцож, амжилт гаргасан байна;
- 5.1.23. мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын инноваци, эрдэм шинжилгээний ажил эрхлэх 300 багшийг холбогдох чиглэлээр сургалтад хамруулсан байна.

5.2. Хөтөлбөрийн үр дүнг дараах шалгуур үзүүлэлтээр үнэлнэ.

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин (2016 он)	Дунд хугацаанд үнэлэх түвшин (2019 он)	Зорилтот түвшин (2021 он)
1	МБСҮЗ-ийн үйл ажиллагаа бэхжин салбар дундын зохицуулалтыг хангах дэд хөтөлбөрийн биелэлт	хувь	0	70,0	90,0
2	Байгуулагдсан үйлдвэрлэл, үйлчилгээний салбар зөвлөл	тоо	4	6	8
3	Албан бус болон амьдрал практикаас олж авсан мэдлэг, ур чадвараа үнэлүүлж, гэрчилгээ авсан иргэд	хүний тоо	0	50-аас дээш	100-аас дээш
4	Шинээр боловсруулсан ажил мэргэжлийн лавлах	тоо	20	30	40
5	Мэргэжлийн боловсрол, сургалтын магадлан итгэмжлэгдсэн байгууллага	тоо	3	10	20
6	Магадлан итгэмжлэгдсэн чадамжид суурилсан сургалтын хөтөлбөр	тоо	8	5	15
7	Мэргэжлийн боловсрол, сургалтын салбарын суралцагчид	хүний тоо	42675	53500	60000
8	Бэлтгэгдсэн үнэлгээний ажилтан	хүний тоо	0	25	45
9	Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин	хувь	62,4	65,0	70,0
10	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан шинэ мэргэжлийн анги	тоо	0	2	5
11	Цахим санд оруулсан мэргэжлийн чадамж	тоо	0	15	20
12	Аж ахуйн нэгж байгууллагад дадлага хийж, ур чадвараа дээшлүүлсэн мэргэжлийн багш	хүний тоо	30	400	700
13	“Мэргэжлийн боловсрол, сургалтын багшийн хөгжил” хөтөлбөрийн биелэлт	хувь	10,0	70,0	90,0
14	“Дэлхийн ур чадвар” тэмцээнд оролцсон байдал	тоо	1	1	2
15	Инновацийн болон эрдэм шинжилгээний ажил эрхлэх сургалтад хамрагдсан багш	хүний тоо	0	200	300
16	Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын төгсөгчдийн байгуулсан аж ахуйн нэгж	тоо	0	30	90

Зургаа. Хөтөлбөрийн санхүүжилт

6.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

- 6.1.1. улсын болон орон нутгийн төсөв;
- 6.1.2. Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан;
- 6.1.3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан;
- 6.1.4. олон улсын байгууллага, гадаад улсын зээл, тусламж;
- 6.1.5. бусад.

Долоо. Хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ

7.1. Хөтөлбөрийн хэрэгжилтэд мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ.

7.2. Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хөтөлбөрийн 7.1-д заасан чиг үүргийн хүрээнд дараах ажлыг зохион байгуулна:

- 7.2.1. хөтөлбөрийн хүрээнд тухайн жилд хийхээр төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнг дараа жилийн 1 дүгээр улиралд багтаан Засгийн газарт танилцуулах;
- 7.2.2. хөтөлбөрийн хэрэгжилт дунд хугацааны зорилтот түвшинд хүрсэн эсэхэд 2019 оны эхний улиралд багтаан үнэлгээ хийж дүгнэлт, зөвлөмж гаргах;
- 7.2.3. хөтөлбөрийн биелэлт зорилтот түвшинд хүрсэн эсэхэд 2021 оны эхний хагас жилд багтаан үнэлгээ хийж, үр дүн, үр нөлөөг тодорхойлон цаашид авах арга хэмжээний талаар дүгнэлт, зөвлөмж гаргах.



Зөвлөх редактор:

Б.АЛТАНЖАРГАЛ

Хөдөлмөрийн яамны

Мэргэжлийн боловсрол, сургалтын бодлого зохицуулалтын газрын дарга

Боловсруулсан:

Б.БАЙГАЛМАА

Хөдөлмөрийн яамны

Мэргэжлийн боловсрол, сургалтын бодлого зохицуулалтын газрын ахлах мэргэжилтэн

Г.БАТЧИМЭГ

Хөдөлмөрийн яамны Мэргэжлийн боловсрол, сургалтын бодлого зохицуулалтын газрын мэргэжилтэн

Ц.ГАНЧИМЭГ

АХБ-ны «Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх» төслийн мэргэжилтэн

С.ГАРАМХАНД

МУИС-ийн Төгсөлтийн дараах сургуулийн мэргэжилтэн

Европын холбооны «Монгол Улсын техник, мэргэжлийн боловсрол, сургалтын салбарыг дэмжих төсөл-1»-ийн санхүүжилтээр хэвлэв.

800 ширхэг хэвлэв.

Зохиогчдын зөвшөөрөлгүй хэвлэн олшруулахыг хориглоно.